Эрэгтэйчүүд

- 1.5.22. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд "Аав, эрчүүд", "Чанартай амьдрал - аавуудын оролцоо", "Эрүүл эр хүн" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.5.23. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

- 1.5.24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.
- 1.5.25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлж дотоодын давуу эрх олгоно.
- 1.5.26. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг нэвтрүүлж, судалгаанд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

87

- 1.5.27. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асрамжийн төвийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.5.28. Баруун бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийг түшиглэн иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.29. Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.5.30. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж иргэний эрхээ эдлэх боломжоор хангана.

1.6.Төрийн албан хаагч, ажилтны нийгмийн баталгаа

- 1.6.1. Сум болон аймгийн төвд ажиллаж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.6.2. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 1.6.3. Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлэн, төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишгт нийцүүлнэ.
- 1.6.4. Төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь "маш сайн" үнэлэгдсэн төрийн албан хаагчийг "1+2" буюу гадаад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлого баримтална.
- 1.6.5. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 1.6.6. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтална.
- 1.6.7. Ажилтныг шударга үнэлэх, зохих цалин хөлсний хэмжээг тогтоох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг ажиллагсдад тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхэд Үйлдвэрчний эвлэлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлж нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрийг үр дүнд хүргэнэ.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд

1.6.8. “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулж, cjob.gov.mn платформоор дамжуулан ажилд зуучлах хөдөлмөрийн яармагийг улирал бүр тогтмол зохион байгуулна.

1.6.9. “Миний түрээсийн орон сууц” дэд хөтөлбөрт зорилтот бүлгийн өрхүүдийг хамруулна.

1.7. Хөдөлмөр эрхлэлт

1.7.1. Шинэ Ховд, Үйлдвэр технологийн парк, Агро парк, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, боомтын сэргэлт, уул уурхайн томоохон төслүүдийг түшиглэн бүсийн хэмжээнд 2500 ажлын байрыг шинээр бий болгоно.

1.7.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гүйцэтгэхдээ орон нутгийн иргэдийг түр болон байнгын ажлын байраар ханган ажилласан байдлыг харгалзан дотоодын давуу эрх олгоно.

1.7.3. Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.7.4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийж, үр дүнд үндэслэн хүний нөөцийг бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах, зуучлах ажлыг цогц байдлаар зохион байгуулна.

1.8. Соёл, урлаг

1.8.1. Үндэсний өв, уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн “ЖАНГАР” олон угсаатны өв соёл дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлан таниулж, урамшуулна;
- Олон угсаатны өв соёлын наадмуудыг зохион байгуулна;
- Хөөмий, тууль, домбор, уран нугаралт, бий биелгээний төрлүүдийг бодлогоор дэмжиж, өв тээгчдийг урамшуулна.

1.8.2. Үндэсний соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж, дэлхий дахинд сурталчлан таниулах замаар баруун Монголын өв соёлын орон зай, үнэ цэнийг өсгөх контент бэлтгэгчдийг дэмжинэ.

1.8.3. Угсаатны соёлын өвийг хадгалан хамгаалах, ондоошлыг илэрхийлсэн “Олон угсаатны урлаг дэлхийн тайзнаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.8.4. Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн музейн барилгыг барьж, соёлын үнэт олдвор, ховор үзмэрүүдийг орон нутагтаа хадгалан хамгаалж, иргэд, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.8.5. Олон улсын соёлын арга хэмжээнд Ховд аймгаа төлөөлөн оролцох уран бүтээлчдийг дэмжинэ.
- 1.8.6. Эртний түүхт Ховд хотын соёлын ордон байгуулна.
- 1.8.7. Төв номын сангийн барилгыг орчин үеийн стандартад нийцүүлэн шинээр барьж, танхим болон цахим уншлагын танхим байгуулж, номын фондыг нэмэгдүүлнэ.
- 1.9. **Спорт**
 - 1.9.1. Нийтийн спорт хөгжих орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд стандарт шаардлага хангасан хөл бөмбөгийн талбай байгуулна.
 - 1.9.2. 3х3 сагсан бөмбөгийн талбайг сум бүрд байгуулна.
 - 1.9.3. Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээлдэхэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлнэ.
 - 1.9.4. Ховд аймгийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлж, "АВАРГА" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Олимп, дэлхий, олон улс, улсын хэмжээний спортын тэмцээн, уралдаанд амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагчдыг урамшуулна;
 - Үндэсний спортын төрлүүдээр амжилт гаргасан тамирчдыг урамшуулна;
 - Олон улсын болон улс, бүсийн аварга шалгаруулах спортын тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна;
 - Биеийн тамир, спортын салбарыг шаардлагатай тоног төхөөрөмж, спорт хэрэгслээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна;
 - Сум бүрд спортын дасгалжуулагч ажиллуулна;
 - Үндэсний спортын холбоод болон бусад холбоодод жил бүр дэмжлэг үзүүлнэ.
 - 1.9.5. Баруун бүсэд 3000-5000 хүний суудалтай "KHOVD PALACE" спорт цогцолборыг шинэ суурьшлын бүсэд шинээр барина.
 - 1.9.6. "Алдрын түүчээ" үндэсний бөхийн чуулга барилдааныг жил бүр уламжлал болгон Ховд бөхийн дэвжээтэй хамтран зохион байгуулна.

- 1.9.7. Спортын холбоодтой хамтран ажиллаж нийтийн биеийн тамир болон мэргэжлийн спортуудыг тэгш хөгжүүлнэ.
- 1.9.8. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын (урбан) спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийг суурин газруудад бүтээн байгуулна.
- 1.9.9. Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудыг түшиглэн шинээр спорт заал барьж, хүүхэд залууст чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэж, эрүүл чийрэг бие бялдартай болоход бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.9.10. Жаргалант сумын бага зааланд их засвар хийж иргэд үйлчлүүлэх ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ.



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО**2.1 Улсын болон орон нутгийн төсвийн бодлого**

- 2.1.1. Эдийн засгийн үр өгөөжтэй, ажлын байр бий болгох төсөл, хөтөлбөр, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, дэмжлэгээр санхүүжүүлэх бодлого баримтална.
- 2.1.2. Бизнесийн бүх салбаруудыг дэмжиж эдийн засгийн хувьд бие даасан аймаг болно.

2.2 Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт уул уурхайн шилжилт

- 2.2.1. Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох ажлыг иргэдийн санал хүсэлтэд үндэслэн шийдвэрлүүлнэ.
- 2.2.2. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, Хөшөөтийн уурхайн тоосжилтын хүн болон мал амьтан, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах дэвшилтэт технологид тулгуурласан нүүрс угаах үйлдвэрийг барина.
- 2.2.3. Уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх замаар хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж дүйцүүлэн хамгаална.
- 2.2.4. Хөшөөтийн нүүрсний уурхайд ажиллаж буй тээвэрчид, уурхайчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хөдөлмөр хамгааллыг хангахад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулна.
- 2.2.5. Ховд аймагт Хөшөөтийн уурхайгаас ирэх үр ашгийг нэмэгдүүлж орон нутгийн компаниудыг дэмжих, хамтран ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3. Нэмүү өртөг шингээсэн боловсруулах үйлдвэр**
- 2.3.1. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг шинээр барьж ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулж ажлын байр бий болгож, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.3.2. Барилгын арматурын үйлдвэрийг барьж баруун бүсийн иргэдийг хямд үнэтэй орон сууц худалдан авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.3. Хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшил тогтоож, дахин боловсруулахад Япон улсын туршлагыг нэвтрүүлж, дэвшилтэт технологиор дахивар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр байгуулна.

2.3.4. Бага оврын нефть боловсруулах үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

2.4. Боомтын сэргэлт, бүс холбосон зам, тээвэр, логистик

2.4.1. Мянганы замын Ховдын Мянгад-Завханы Загастайн давааны арын уулзвар чиглэлийн 426 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.2. Мянганы замын Ховдын Мянгад-Хонгиогийн гүүр хүртэлх 32 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.3. Ховд – Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.4. Босоо, хэвтээ тэнхлэгийн замын огтлолцлыг түшиглэн хуурай боомтыг байгуулна.

2.4.5. Ховд Нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөл хийнэ.

2.4.6. Евро-Азийг холбосон хамгийн дөт зам Шивээхүрэн боомт - Арцсуурь боомт чиглэлийн баруун босоо тэнхлэгийн 725 км төмөр замыг барина.

2.4.7. Булган, Байтаг боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, ачаа тээврийн бүртгэл, гаалийн хяналт шалгалтыг автоматжуулж, рентген, камер, автомат хаалга, автомат жин, шинжилгээний төхөөрөмжийг суурилуулан боомтын “Ухаалаг гарц”-ыг бүрэн ашиглалтад оруулна.

2.4.8. Мөнххайрхан, Дуут сумыг аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбож бүх сумаа хатуу хучилттай авто замаар холбосон анхны аймаг болно.

2.4.9. Улс, хот хоорондын ачаа, авто тээврийн мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгон олон улсын жишигт хүргэж иргэд үйлчлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.10. Нийтийн тээврийн үйлчилгээг дэмжин, ухаалаг үйлчилгээг нэвтрүүлж, иргэдэд үйлчлэх тав тухтай байдлыг нэмэгдүүлнэ.

2.4.11. Булган суманд малын эрүүл ахуйн хорио цээрийн бүс байгуулж, мал, махны экспортыг нэмэгдүүлнэ.

2.5. Эрчим хүчний шилжилт

2.5.1. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж, баруун бүс нутгийг хямд өртөгтэй эрчим хүчээр хангана.

2.5.2. Эрдэнэбүрэн – Мянгад - Улиастайн чиглэлийн 220 кВ-ын 468.3 км цахилгаан дамжуулах агаарын шугам татна.

- 2.5.3. Алтай, Булган, Үенч сум, зарим сумдын багийн төвийг цахилгаан дамжуулах нэгдсэн шугам сүлжээнд холбоно.
- 2.5.4. Буянт, Мөст сумыг дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбож бүх сумдаа дулааны эх үүсвэрээр хангана.
- 2.5.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг бодлогоор дэмжинэ.
- 2.5.6. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 2.6. Дөрвөн улирлын аялал жуулчлал ба Соёлын бүтээлч үйлдвэрлэл**
- 2.6.1. “Мөнгөлөг шагшурга” цас мөсний баяр, “Жангар-Цайны зам” өв соёлын наадмыг үргэлжлүүлж, гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 2.6.2. Гурван Сэнхэр, Дөргөн нуур, Хар ус нуур, Буянт, Ховд гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд, Хил орчмын бүсийг түшиглэсэн аялал жуулчлалын бааз байгуулах санал санаачлагыг дэмжинэ.
- 2.6.3. Ховд аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялагчдын аялах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аялал жуулчлалын түр буудаллах цэгийг Булган, Манхан, Мөст, Дарви, Эрдэнэбүрэн сумдад байгуулна.
- 2.6.4. Аялал жуулчлалын бүс нутгууд болох Эрдэнэбүрэн сумын Намарзан баг, Мөст сумын Баянзүрх, Бодончийн хавцал, Алтай сумын Ямаан усны хавцал, Чандмань сумын Дөргөн хатан нуур, Жаргалант сумын Буянт гол, Дарви сумын Сутай, Булган сумын Бүдүүн харгайтын голыг түшиглэн жуулчдын отоглох цэгийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 2.6.5. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээлээр дэмжих бодлого баримтална.
- 2.6.6. Аялалын гол маршрутуудын дагуу жуулчдад зориулсан тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбарыг байршуулж, дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.6.7. Өөрийн орны өвөрмөц онцлог, нөөц, олон улсын чиг хандлага, технологийн хөгжилтэй уялдсан, мэдээт суурилсан бүтээлийг дэмжиж, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх бүтээлч экосистемийг дэмжих “Соёлын бүтээлч үйлдвэрлэл III” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.6.8. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг (AR, VR, MR, 3D) ашиглаж, “Цахим соёл II”, “Соёлын эрхийн бичиг” системийг орон нутагтаа нэвтрүүлнэ.

- 2.6.9. Алтайн нуруу, их нууруудын экосистемд түшиглэсэн адал явдалт, ангийн, угсаатан зүй, хил орчмын болон хил дамнасан, олон угсаатны аялал жуулчлалыг кластер бүсчлэлээр хөгжүүлж, Их нууруудад түшиглэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 2.6.10. Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулна.
- 2.7. “Шинэ хоршоо” хөдөлгөөн- Хөдөөгийн сэргэлт**
- 2.7.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг орон нутгийн дэмжээнд өрнүүлж, хоршоологчдыг дэмжинэ.
- 2.7.2. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг бүрдүүлнэ.
- 2.7.3. Агро парк, Шинэ хөдөө төслийн хүрээнд худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.7.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дутагдалтай байгаа малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэхэд орон нутаг бодлогоор дэмжинэ.
- 2.7.5. Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.
- 2.7.6. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байр бий болгох бодлогыг сум бүрд хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

- 2.7.7. Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.
- 2.7.8. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон салбар болгон хөгжүүлнэ.
- 2.7.9. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.
- 2.7.10. Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлана.
- 2.7.11. Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг байгуулна.

- 2.7.12. Малын тэжээлийн баруун бүсийн үйлдвэрийг байгуулж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 2.7.13. Гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх хувийн хэвшлийн санаачилгыг бодлогоор дэмжинэ.
- 2.7.14. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорины аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, аймгийн хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 2.7.15. Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 2.7.16. Газар тариалан эрхлэгчдийг дэвшилтэт технологид суурилсан техник, тоног төхөөрөмжөөр хангахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт, экспорт

- 2.7.17. "Шинэ Ховд" хөнгөн үйлдвэрлэл технологийн паркийг түшиглэн мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хагас болон гүн боловсруулах инновац, технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.7.18. Сүү, цагаан идээ, мах, нослуур, арьс ширийг нэмүү өртөг шингэсэн дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.
- 2.7.19. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.7.20. Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариалангын талбайн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж, "Атар IV" аяныг хэрэгжүүлнэ.
- 2.7.21. Ховд аймгийн онцлогт түшиглэн газар тариалангийн салбарт олон улсын дэвшилтэт технологи нэвтрүүлж, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлж тариаланчдын орлогыг 2-3 дахин өсгөнө.
- 2.7.22. Зооноз өвчин судлалын төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

Эрүүл хүнс

- 2.7.23. Тарвас, Булганы алимыг газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр баталгаажуулж экспортын брэнд бүтээгдэхүүн болгоно.
- 2.7.24. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.
- 2.7.25. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, стандартыг нэмэгдүүлж, эрүүл, чанартай хүнс хэрэглэх тогтолцоог сайжруулна.
- 2.7.26. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар орон нутгийн малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.
- 2.7.27. Баруун бүсийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулж иргэдийн хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.



ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

3.1. Төр нь хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй

- 3.1.1. Булган, Байтаг боомтоор хувь хүн, ААН-үүдийн импорт, экспортын бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдэд ээлтэй, шуурхай үйлчилгээний шинэ менежментийг бий болгоно.
- 3.1.2. Орон нутгаас зарлагдаж буй төрийн худалдан авах ажиллагаанд орон нутгийн аж ахуйн нэгж, компаниудыг бодлогоор дэмжиж, чадавхжуулна.
- 3.1.3. Бизнес эрхлэлтийг бодлогоор дэмжиж төрөөс зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод, түргэн шуурхай болгоно.
- 3.1.4. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин ажиллаж, хамтарсан хяналтын тогтолцоог бий болгоно.

3.2. Шинэ ажлын байр

- 3.2.1. Томоохон бүтээн байгуулалт, уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компаниудыг орон нутгийн аж ахуй нэгж, жижиг дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг бойжуулах зорилгоор дэмжих, туслан гүйцэтгэгчээр ажиллуулах, худалдан авалт хийх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.3. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг орон нутгийн худалдан авалтаар дэмжинэ.
- 3.2.4. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 3.2.5. Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ТӨРИЙН БҮТЭЭМЖ БА ЦАХИМ ЗАСАГЛАЛ

4.1. Цахим засаглал

- 4.1.1. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар иргэдийн хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "ухаалаг E-Mongolia" системийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах замаар төрийн үйлчилгээг иргэдэд ээлтэй, хурдан шуурхай болгох ажлыг чанарын шинэ шатанд гаргана.
- 4.1.2. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүний оролцоогүй болгох дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.1.3. Төрийн үйлчилгээний 24 цагийн цахим төвийг бүх сумдад байгуулна.
- 4.1.4. Олон улсын цахим төлбөрийн системүүдийг нэвтрүүлж, төлбөр тооцоог саадгүй хүлээн авах боломжийг орон нутагтаа бүрдүүлэн цахим худалдааг дэмжинэ.
- 4.1.5. Мэдээлэл технологийн салбарын инженерүүдийг бэлтгэх, чадавхжуулах бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.1.6. Баруун бүсийн дата төвийг Ховд аймагт байгуулна.
- 4.1.7. Хур-Дан төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 4.1.8. Invest Khovd, My Khovd, Visit Khovd төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн үйл ажиллагааг өргөтгөнө.
- 4.1.9. Интернэтийн 5G сүлжээг бүрэн нэвтрүүлнэ.

ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН**5.1. Уур амьсгалын өөрчлөлт**

- 5.1.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй ажил, үйлчилгээ, бизнесийг орон нутгийн бодлогоор дэмжинэ.
- 5.1.2. Хүлэмжийн хийг бууруулах стратегийг утаа, эрчим хүч, өрхийн халаалтын шийдэл, цөлжилт зэрэг тулгамдсан асуудлууд руу чиглүүлж, олон улсын байгууллагуудаас санхүүжилт татах бодлого хэрэгжүүлнэ.
- 5.1.3. Аймгийн ус цаг уурын орчны шинжилгээний салбарт өндөр технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн техникийн шинэчлэл хийж, цаг уур, гамшгийг эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана.
- 5.1.4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх дэвшилтэт технологи ашиглах хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.5. Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлыг хамгаалах, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлийн олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.1.6. Хар ус нуурын эко системийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

5.2. Уламжлалт нүүдлийн аж ахуй

- 5.2.1. Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг дэмжих замаар бэлчээрийн доройтлыг бууруулна.
- 5.2.2. Залуу малчдыг уламжлалт болон эрчимжсэн мал маллах арга ухаанд сургах, залгамж халааг бэлтгэнэ.
- 5.2.3. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах замаар ашиглагч-малчдыг хариуцлагажуулна.
- 5.2.4. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 5.2.5. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэргч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 5.2.6. Эвдэрсэн худаг, уст цэгийг сэргээж, бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлнэ.

5.3. Үнэт баялаг ус

- 5.3.1. Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.
- 5.3.2. Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, саарал ус ашигладаг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 5.3.3. Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, үйлдвэрлэлийн ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.3.4. Суурин газруудын ундны усан хангамжийн эх үүсвэрийг бий болгож, ухаалаг систем нэвтрүүлж тоолууржуулна.
- 5.3.5. Усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлнэ.

5.4. Ногоон эдийн засгийн шилжилт

- 5.4.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж 20 сая мод тарьж, ургуулна.
- 5.4.2. Ногоон хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжийн удирдлага, бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.4.3. Хог хаягдлын дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэр барина.
- 5.4.4. Ухаалаг, хэмнэлттэй хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 5.4.5. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц, дэд бүтцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.4.6. Сумдыг бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, эдийн засгийн тэргүүлэх салбарыг кластерын системээр хөгжүүлэх бодлого баримтална.

ЗУРГАА . СУМ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1. Сумын хөгжил

- 6.1.1. Сумын төвүүдийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
- 6.1.2. Цахилгааны хүчдэлийн алдагдлыг бууруулж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өргөөнүүдийг өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.1.3. Сумын төвийн ундны эх үүсвэрүүдийг бий болгож, ухаалаг систем нэвтрүүлэн тоолууржуулж усны алдагдлыг бууруулна.
- 6.1.4. Сум бүрд Ардын өргөө байгуулна.
- 6.1.5. Сум бүрд сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 6.1.6. Малын гаралтай түүхий эдийн малчдын хотноос авч төвлөрсөн үйлдвэр, цехэд хүргэх үйлчилгээг бий болгоно.
- 6.1.7. Хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах үүднээс сумын эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн барилга байгууламжийг өргөтгөх, засвар шинэчлэл хийх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.1.8. “Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа” төслийг сум бүрд хэрэгжүүлнэ.
- 6.1.9. Хөдөөгийн сумдал хүний нөөцийг тогтвортой ажиллуулах бодлогын хүрээнд төрийн албан хаагчдын цалинг үе шаттай нэмэгдүүлж нийгмийн баталгааг хангана.
- 6.1.10. Бүх сумыг аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбоно.
- 6.1.11. Нүүрс угаах, малын түүхий эд боловсруулах үйлдвэр барина.
- 6.1.12. Бүх сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж мөрдөнө.

АЛТАЙ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд өргөтгөл хийж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Боомын амын услалтын системийг бүрэн дуусгана.
3. Эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдоно.
4. Ардын өргөө барина.
5. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
6. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
7. "Алтайн улаан ямаа" үүлдрийн цөм сүргийг сэргээнэ.
8. Барлаг чиглэл рүү явах Бодонч гол дээр бетонон гүүр барина.
9. Барлаг, Алтангадас багийн төвийг дайран өнгөрч байгаа ЦДАШ-наас салбарлаж 0.4 квтын шугам татна.
10. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
11. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
12. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

БУЛГАН СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээний өргөтгөлийг хийж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. "Байтаг Богд" боомт хот болгон хөгжүүлнэ.
3. Байтаг, Булган боомтын өргөтгөл хийгдэнэ.
4. Ардын өргөө барина.
5. Малын эрүүл ахуй, хорио цээрийн бүс байгуулна.
6. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
7. Булганы алимьт газар зүйн заалттай болгоно.
8. Сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
9. Төвлөрсөн цахилгаан, эрчим хүчний системд холбоно.
10. Нийтийн төвлөрсөн халуун ус барина.
11. Авто зогсоол болон явган хүн, дугуйн замыг барина.
12. Эрчим хүчний 0.4 шугам трансформатор 5 чиглэлд татаж хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
13. Жимс жимсгэнэ хөтөлбөр хэрэгжүүлнэ.
14. Хөдөөгийн зарим багийг цахилгаан эрчим хүчний шугамд холбоно.
15. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төслийг хэрэгжүүлнэ.

16. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
17. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
18. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
19. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
20. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

БУЯНТ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
3. Ардын өргөө барина.
4. Цэвэр бохирын нэгдсэн шугам сүлжээнд айл өрхүүдийг холбоно.
5. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
6. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
7. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
8. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг бүрэн дуусгана.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
10. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
11. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ДАРВИ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Нүүрс угаах үйлдвэр барина.
6. Мах боловсруулах үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.
7. Мөрөнний услалтын системийг бүрэн ашиглалтад оруулна.

8. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
9. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
10. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
11. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ЗЭРЭГ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд өргөтгөл хийж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. “Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудaa” төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Дотуур байрны барилгын өргөтгөлийг барьж ашиглалтад оруулна.
6. Эрүүл мэндийн төвийн их засвар хийнэ.
7. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

МАНХАН СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд өргөтгөл хийж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Эрчим хүчний нэгдсэн системтэй холбоно.
3. Ардын өргөө барина.
4. “Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудaa” төсөл хэрэгжүүлнэ.
5. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
6. Гурван Сэнхрийн агуйг баруун бүсийн аялал жуулчлалын төв болгон тохижуулж хатуу хучилттай авто замтай холбоно.
7. Босоо, хэвтээ замын огтлолцлыг түшиглэн тээвэр, логистикийн төв байгуулна.
8. Улаанхүрээ, Баянгол багуудын цахилгаан дамжуулах нэгдсэн сүлжээнд холбоно.
9. Өөшид усалтын систем байгуулна.
10. Сумын төвийн худгуудыг ухаалаг болгоно.

11. Ойрад Монголын соёл мэдээллийн төв байгуулна.
12. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
13. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
14. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

МӨСТ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир ус, дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
4. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
5. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
6. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
7. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
8. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

МӨНХХАЙРХАН СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. “Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа” төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбоно.
6. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
7. Мөнххайрхан уулыг түшиглэсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулна.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
10. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ЦЭЦЭГ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Баян-Овоо, Хажинга багт хөв цөөрөм байгуулж, тэжээлийн ургамал, хадлангийн нэгдсэн талбай байгуулна.
6. Цахилгааны хүчдэлийн алдагдлыг бууруулж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөнүүдийг өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
7. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг бүрэн дуусгана.
10. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
11. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ХОВД СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
3. Ардын өргөө барина.
4. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
5. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
6. Цэцэрлэгийн барилга шинээр барина.
7. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр барина.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
10. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ЧАНДМАНЬ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, дулааны станц, шугам, сүлжээнд өргөтгөл хийж иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Аялал жуулчлалын бүс байгуулна.
6. Сумын төвд 2 км засмал зам тавина.
7. Сумын төвийг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.
8. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
9. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
10. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
11. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ЭРДЭНЭБҮРЭН СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
3. Ардын өргөө барина.
4. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
5. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
6. Шураг багийн төвийг цахилгаан шугам сүлжээнд холбоно.
7. Эрүүл мэндийн төвийг шинээр барина.
8. Соёлын төвийн өргөтгөл их засвар хийнэ.
9. Бандийн хөндийд хөв цөөрөм байгуулна.
10. Галдан бошигт хааны үндэсний цэцэрлэгт хүрээлэн барина.
11. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
12. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг бүрэн дуусгана.
13. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
14. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ШИНЭ ХОВД ХОТ**7.1.Хот төлөвлөлт, хотын стандарт**

- 7.1.1. Насжилт өндөртэй 12 айл, 24 айл, 36 айл зэрэг орон сууцнуудыг иргэдийн оролцоотойгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дахин төлөвлөлт хийж байгаль орчин, иргэндээ ээлтэй ногоон хорооллыг бий болгоно.
- 7.1.2. Жаргалант сумын шаардлагатай байршлуудад хотын стандарт нийцсэн дахин болон хэсэгчилсэн төлөвлөлт хийнэ.
- 7.1.3. Шинэ суурьшлын бүсүүдэд авто зам, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцийг бий болгоно.
- 7.1.4. Ховд хотын хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах ундны усны хоёрдох эх үүсвэрийг бий болгоно.
- 7.1.5. Шинэ дулааны станцын өргөтгөлийг бүрэн дуусгаж дулаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 7.1.6. “Бадамлах дөл” дулааны станцын хэрэглэгч айл өрхийн дулаан хангамжийг сайжруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.
- 7.1.7. Баруун бүсийн KHOVD PALACE спортын цогцолбор, Жаргалант сумын ЖАНГАР соёлын ордон, Баруун бүсийн эрдэм шинжилгээний төв, Баруун бүсийн эмчилгээ оношилгооны төвийн өргөтгөл, МУИС-ийн баруун бүсийн сургуулийн оюутны дотуур байр, номын сангийн цогцолбор, шинэ суурьшлын бүсэд сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгуудыг барина.
- 7.1.8. Ховд хотын авто зам, замын байгууламжид бүрэн шинэчлэл, өргөтгөл, засвар хийнэ.

7.2.Орон сууц ба гэр хороолол

- 7.2.1. Шинээр баригдсан орон сууцны хорооллуудын гадна тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол, тоглоомын талбай зэргийг аж ахуй нэгжүүдтэй хамтран бий болгож иргэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 7.2.2. Дэвшилтэт технологи, шинэ стандартад нийцүүлэн хуучин орон сууц, барилга байгууламжийн гадна фасад, дээвэр засварлаж, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 7.2.3. Ундны усны шугамыг зэс хоолойгоор солих судалгаа хийж, усны эзвийг арилгах зорилгоор цэвэр усны шугамыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.
- 7.2.4. “Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа” төслийг үргэлжлүүлэн гэр хорооллын утааг багасгаж, нүхэн жорлонгийн тоог цөөрүүлж, хөрсний бохирдлыг бууруулах стандарт, нөхөн сэргээх, ногоон байгууламжуудыг бий болгох ажлыг цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.
- 7.2.5. Ногоон эзэлийн санхүүжилтээр олон улсын байгууллагатай хамтран хашаа бүрд өрхийн нарны дэлгэц, цахилгаан хураагуур, халаалтын системийн

тогтолцоог бий болгох, байшин - гэр хорооллын дулаалга, дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.

7.3. Ногоон хот

- 7.3.1. Ховд хотын төвөөс 1000 метрийн радиуст шороон талбайгүй ногоон бүс бүхий тохижилтыг бий болгоно.
- 7.3.2. “Жимс жимсгэнэ” хөтөлбөр хэрэгжүүлж эрүүл эко, жимсний хот бий болгоно.
- 7.3.3. Ойн бүсэд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэд олон нийт амрах ногоон бүс бий болгоно.
- 7.3.4. Жаргалант сумын баг бүрийн нутаг дэвсгэрт ногоон байгууламж бүхий амарч, тухлах цэцэрлэгтэй болно.
- 7.3.5. Хууль бусаар олгосон газрыг төрд буцаан авах, нийтийн эзэмшлийн газар, талбайд зөвшөөрөлгүй барьсан байгууламжийг буулгах ажлыг үргэлжлүүлж, уг газарт ногоон байгууламж барина.
- 7.3.6. Алхах, дугуй унахад аюулгүй тав, тухтай явган хүний болон дугуйн замуудыг тавина.
- 7.3.7. Хашаандаа сайхан амьдаргааа Ховдчуудад төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж амины орон сууцандаа хямд зардлаар ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

7.4. Ухаалаг хот

- 7.4.1. Хөдөлгөөн удирдлагын төвийн системийг хиймэл оюун ухаанд нэвтрүүлж, гэрлэн дохионы зохицуулалтыг хөдөлгөөний урсгалаас хамаарч ухаалгаар зохицуулах боломжийг бүрдүүлнэ.
- 7.4.2. Ховд хотыг бүрэн камержуулж, хэмжилтийн мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулах, хотын хөдөлгөөн, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй авч анализ хийдэг, зохицуулах арга хэмжээ авдаг системийг хөгжүүлнэ.
- 7.4.3. Гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэл гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай шинэчлэх арга хэмжээ авна.
- 7.4.4. Цэвэр усны алдагдлыг бууруулах ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлнэ.
- 7.4.5. Хотын нийтийн тээврийн бодлогыг шинэчлэн боловсруулж, алслагдсан бүсийн иргэд ая тухтай зорчиход зориулсан олон хэлбэрийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 7.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгоно.

7.5. Хотын эдийн засаг

- 7.5.1. 1000 тонн нарийн ногоо хураах өвлийн хүлэмжийн кластер бүхий тусгай бүсийг “Агропарк” цогцолборыг бүрэн дуусгана.
- 7.5.2. “ШИНЭ ХОВД” , “Агро парк” хөнгөн үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалтыг бүрэн дуусгана.
- 7.5.3. “Эко парк” Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах. Хог хаягдал ангилан ялгаж хүлээн авах цэг байгуулах. Жилд дунджаар 60 мян.тн хог хаягдал төвлөрсөн хогийн цэгт булшилж байна үүний 30-40 хувийг дахин боловсруулах боломжтой байдаг.
- 7.5.4. Эртний түүхт Ховд хот аялал жуулчлалын хөтөлбөр гаргаж аялал жуулчлалын салбараас орж ирэх орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 7.5.5. Баруун бүсийн хүүхдийн паркийн үйл ажиллагааг өргөтгөж, жилийн 4-н улирал ажиллуулж, бүсийн соёл амралтын цогцолбор болгон эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

7.6.Хотын дэд бүтэц

- 7.6.1. Авто замын ус зайлуулах суваг хоолой, үерийн даланг барьж байгуулна.
- 7.6.2. Ховд хотын хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцүүлэн бохир усны дэд станц, шугам хоолойг шинэчилж цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 7.6.3. Ховд хотын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 К.в болгож, хүчдэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн зарим дэд станцыг өргөтгөнө.
- 7.6.4. Хотын газар доорх инженерийн дэд бүтцийн байгууламжийн шинэчлэлийг үе шаттайгаар бүрэн шинэчилнэ.

НАЙМ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

8.1. Ухаалаг засаглал ба бүтэц

- 8.1.1. "Баруун бүсийн алсын хараа-2050" бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 8.1.2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулна.
- 8.1.3. Хот, сумын хөгжлийн төлөвлөлтөд үндэслэн иргэн бүрд 0.07 га газрыг өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж, газар олголтыг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- 8.1.4. Иргэдэд газар олгох үйл явцыг хиймэл оюун ухаанд тулгуурлан egazar.gov.mn системээр дамжуулж, хүний оролцоогүй шийдвэрлэдэг болно.
- 8.1.5. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуультай ажилтныг мэргэшүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.
- 8.1.6. Төрийн албан хаагчдыг иргэн төвтэй, чадварлаг, өндөр бүтээмжтэй, мэргэшсэн, улс төрөөс ангид, дарамтгүй ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 8.1.7. Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд байгуулагдсан зөвлөлдүүдийг бодлогоор дэмжиж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 8.1.8. Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор төрийн албан хаагчдыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, нутгийн удирдлагын ордонд шаардлагатай засвар, шинэчлэлтийг хийнэ.

8.2. Бүс нутгийн хамтын ажиллагаа, гадаад харилцаа

- 8.2.1. "Бүс ба зам" санаачилгын хүрээнд Хятад, Монгол, Оросын эдийн засаг, дэд бүтэц, шинжлэх ухаан, нийгэм соёлын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 8.2.2. Хөрш орнуудын уламжлалт харилцаатай хот мужуудтай харилцаа хамтын ажиллагаагаа улам хөгжүүлж "Алтай бидний нийтийн гэр" олон улсын байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- 8.2.3. Гуравдагч орнуудын аймаг, мужуудтай эдийн засаг, соёл, боловсрол, дэд бүтэц, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах бодлого баримтална.
- 8.2.4. Экспорт хийх, бусад улс орноос хөрөнгө оруулалт, дэвшилтэт техник, технологийг татахыг дэмжсэн гадаад бодлого хэрэгжүүлнэ.

8.3. Батлан хамгаалах

- 8.3.1. Цэрэг, эх оронч үзэлд суурилсан "Оюутан цэрэг" хөтөлбөрт хамрагдах оюутны тоог шат дараатай нэмэгдүүлж, хугацаат цэргийн алба хаах хугацаанд мэргэжил, ур чадвар олгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 8.3.2. Сум бүрд гамшгийн эрсдэлийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.
- 8.3.3. Гамшгийн эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана.

- 8.3.4. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, боловсролын түвшин дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 8.3.5. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, орон нутгийн төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ.

8.4. Амар тайван орчин

- 8.4.1. “Авлига - хүнд сурталгүй” аймаг болох зорилтоо цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн албаны бүх шатанд хариуцлага, сахилга бат, соёлтой боловсон харилцааг нэвтрүүлж ил, тод, нээлттэй төрийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 8.4.2. Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн ногоон бүс бүхий анхны аймаг болно.



ХОВД АЙМАГ
МАНХАН СУМ

МАНХАН СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН 2024-2028 ОНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2024 ОН

1.1.6. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, хүүхэд, залуучууд, гэр бүлд мэдээ мэдээллийг хүргэхэд чиглэсэн "Хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын төв" байгуулна.

1.1.7. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, хөгжих боломжийг бүрдүүлнэ.

1.1.8. Залуучуудыг дэмжих "Залуусын оролцоо", "Залуу гэр бүл" төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, тэдний асран хамгаалагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.10. Ахмад настны хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог сайжруулж, ахмад настныг ажил, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.1.11. Ахмадын өргөөний гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулна.

1.1.12. Төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.1.13. Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.14. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.1.15. Монгол гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд "Аавуудын манлайлал-оролцоо" төсөл арга хэмжээ хэрэгжүүлнэ.

1.2. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал

1.2.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийнэ.

1.2.2 Тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжинэ.

1.2.3 Хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар жил бүр ажлын байр нэмэгдүүлнэ.

1.2.4 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

Боловсрол

1.3.14 Цэцэрлэгийн хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурч, хүмүүжих орчин нөхцөлийг сайжруулан, хүүхдийн насанд тохирсон тоглоом, хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.

1.3.15 Цэцэрлэгийн гадна биеийн тамирын талбай байгуулна.

1.4 Үндэсний бахархал, соёлын өв:

1.4.1 Олон угсаатны соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэх "Олон угсаатны өв, соёл урлаг" төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.2 "Соёлын биет болон биет бус өвийг өвлүүлэн уламжлах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан иргэд, өвлөн уламжлагчдыг урамшуулна.

1.4.3 Түүх соёлын үл хөдлөх, хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн улсын тооллого зохион байгуулж, соёлын өвийг судалгааны эргэлтэнд оруулж, цахим бүртгэлд оруулах ажлыг эрчимжүүлнэ.

1.4.4 Соёлын төвийн урлагийн хувцас, хөгжим, техник хэрэгсэл, уншлагын танхимын ширээ, сандал, номын тавиурыг шинэчилнэ.

1.4.5 Номын сангийн фондын баяжилтыг нэмэгдүүлж, оюуны бүтээл туурвигчдыг дэмжинэ.

1.4.6 Хөдөөгийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг тогтмолжуулна.

1.4.7 Ойрад монголчуудын уламжлалт шашин, соёл, зан үйлийг сэргээхэд анхаарч, "Соёл, уламжлалын төв" төслийг хэрэгжүүлнэ.

1.4.8 Захчин угсаатны өв соёлын өргөө байгуулна.

1.4.9 Бүх нийтээр хос бичигтэн болох бодлогыг дэмжин үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ.

1.4.10 Олон угсаатны соёлын өвийг хадгалан хамгаалж түгээн дэлгэрүүлэх "Өв тээгч гэр бүл, хамт олон" төслийг хэрэгжүүлнэ.

1.5 Биеийн тамир, спорт

1.5.1 Спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх "Спортын аварга" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.5.2 Спорт цогцолборыг түшиглэн аймаг, бүсийн болон орон нутгийн чанартай тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж, спортыг дэмжигч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг сайжруулна.

1.5.3 Спорт цогцолборын шалыг стандартад нийцсэн шалтай болгоно.

1.5.4 Багш дасгалжуулагч нарын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх болон шүүгчийн сургалтанд хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулж, хичээллэх сургалт, секцийн төрөл, тоог нэмэгдүүлж, спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

1.7.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, дэмжих урамшуулах, хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд чиглэсэн "Чадварлаг эмч, мэргэжилтэн" төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.7.6 Эрүүл мэндийн салбарыг бүрэн цахимжуулж, мэдээллийн нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.

1.7.7 Уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх, сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэн байгалийн өвөрмөц тогтоц, рашааныг түшиглэн сувилал байгуулах үйл ажиллагааг дэмжинэ.

1.7.8 Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай техник тоног төхөөрөмж, хатуу, зөөлөн эдлэлийг шинэчилж, үйлчлүүлэгчийн ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

1.7.9 Хүн амд амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг олгох замаар шүдний өвчлөлийг бууруулна.

1.7.10 Жил бүр Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд "Шүд угаалтын аварга анги бүлэг" шалгаруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.7.11 Товлолын болон сайн дурын дархлаажуулалтанд иргэдийг бүрэн хамруулна.

1.7.12 Эмийн бус эмчилгээ, эрүүл зөв хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр эмчлэх эмнэл зүйн арга хэлбэрийг дэмжиж, "Зохистой хөдөлгөөн Эрүүл мэнд" аяныг ахмад, дунд насныхан, залуучуудын дунд өрнүүлж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.7.13 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулах бөгөөд өвлийн улиралд алслагдсан бүс нутгийн малчдын хүүхдийн товллын вакциныг гэрт хүрч хийнэ.

1.7.14 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

1.7.15 Эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээг сайжруулна.

1.7.16 Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулна.

2. ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.1 Орон нутгийн татварын хувь хэмжээг оновчтой тогтоох, татварын бааз, суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.3.12. "Хашаандаа сайхан амьдарцаа" төслийг үргэлжлүүлнэ.

2.3.13. Ногоон хөгжлийн барилгын стандартыг хангасан амины тохилог орон сууц барих санаачилгыг дэмжинэ.

2.3.14. Гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэл, гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай шинэчлэх арга хэмжээ авна.

2.3.15. Гэр хорооллын гудамжинд хатуу хучилттай зам барих ажлыг холбогдох яаманд уламжилна.

2.3.16. Гурван замын бэлчирт тээвэр ложистикийн төв байгуулна.

2.3.17. Аялал жуулчлал, эрчим хүчний бүс болсонтой холбогдуулан 50 мегабайтын цахилгаан станц бариулах ажлыг судална.

2.3.18. Шинэ суурьшлын бүсэд явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, тохижилтын ажил хийж, айл өрхүүдийг суурьших боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

3. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх төв байгуулна.

3.1 Мал аж ахуй

3.1.1 Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малын генийн санг хамгаална.

3.1.2 Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, тарималжуулах, хамгаалах, усжуулах, ургамал хамгааллыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.3 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, худаг уст цэгийг шинээр барихад бодлогоор дэмжинэ.

3.1.4 Хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн боловсон хүчний хүний нөөцийг нэмэгдүүлж, ажиллах нөхцөл, мэдлэг, чадавхыг сайжруулах замаар мал аж ахуйн салбарын хамрах хүрээ, хүртээмж, чанарт өөрчлөлт гаргана.

3.1.5 Залуу малчдыг чадавхжуулах, малжуулах, мэдлэг чадварыг сайжруулна.

3.1.6 "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг өрнүүлж, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлж, мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг сайжруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

3.1.7 Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлж, хоршоогоор дамжуулж малчдын амьжиргааг сайжруулна.

3.3.7 Сүү, сүүн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд, арьс шир, дайвар бүтээгдэхүүний үйлдвэр, мал нядалгааны болон арьс ширний цехийг байгуулж, сав баглаа, боодлыг стандарт хангуулан малчдын орлогийг нэмэгдүүлнэ.

4. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Хүний эрхийг дээдэлсэн, авлига, хүнд сурталгүй, чадварлаг, ухаалаг төрийн албыг бэхжүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулан чанар, хүртээмж, үр дүн, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

4.1 Төрийн алба

4.1.1 Төрийн байгууллагуудын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулж, төрийн үйлчилгээг соёлтой, хүртээмжтэй, шуурхай, хүнд сурталгүй хүргэх нөхцөл бүрдүүлнэ.

4.1.2 Орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцож улсын төсвөөс, төрийн албан хаагчид 80 хувь хүртэл нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг чадавхжуулах, архивын баримтын хадгалалт хамгаалалтын орчин, нөхцөлийг сайжруулна.

4.1.4 Иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх, Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьдаг, үнэлдэг тогтолцоог нэвтрүүлнэ.

4.1.5 Төрийн албаны мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж иргэд, олон нийтэд сурталчилан ажиллана.

4.1.6 "Иргэдээ сонсьё" аяныг зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг сонсож төрийн бодлогод тусгаж ажиллана.

4.1.7 Төрийн засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомж, орон нутгийн цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж хэвшинэ.

4.2 Цахим төрийн үйлчилгээ

4.2.1 Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны нэгдсэн сүлжээг өргөтгөн ажлын уялдаа холбоог сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

4.2.2 Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлэн өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.

4.2.3 Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангана.

4.2.4 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэнэ.

4.3 Төрийн албаны шинэчлэл

4.6.3 Иргэдийн амар тайван амьдрах, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалахад иргэд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

4.6.4 Шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг тухай бүр сурталчилан ажиллана.

5. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүрээлэн буй орныг хамгаалах, бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

5.1 Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах

5.1.1 Байгаль экологийн өвөрмөц тогтоц, ховордсон ургамал, амьтны тархац нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг зохион байгуулж, биологийн олон янз байдлын суурь судалгааг хийнэ.

5.1.2 Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлнэ.

5.2 Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

5.2.1 Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлөх, өндөр уулын бүсэд уулзүйн системийн дагуу газрын генераторын сүлжээ үүсгэнэ.

5.2.2 Суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ.

5.2.3 Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтны ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.3 Агаар, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах

5.3.1 Агаар, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.3.2 Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байхаар оновчтой менежментийг хэрэгжүүлнэ.

5.3.3 Төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэж, хашиж, хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлнэ.

5.4 Аялал жуулчлал:

5.4.1 Байгалийн болон соёлын аялал жуулчлалыг нутгийн иргэдэд түшиглэн хөгжүүлэх цогц төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.

5.4.2 Гурван Сэнхэрийн агуйруу засмал зам тавих ажлыг холбогдох яам, дээд шатанд уламжилна.

5.4.3 "Гурван сэнхэр төвтэй таван од" аялал жуулчлалын хөтөлбөрийн хүрээнд Сэнхэрийн агуй, Жаргалантын хайрхан, Гоогийн нуруу, Хар ус нуур, Тооройн элс зэргийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, отоглох цэг, аялалын маршрут, авто зам

127

Ховд аймгийн Монгол Ардын Намын хорооны
тэргүүлэгчдийн 2024 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**МОНГОЛ
АРДЫН НАМ**

**ХОВД АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ
ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2024.07.23

128

УРИА: БҮСИЙН ХӨГЖЛИЙГ

ХОВДЧУУД МАНЛАЙЛНА



- Суманд нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг сумандаа ирж ажиллахад орон суушны дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.5. Эрүүл мэндийн яаралтай тусламжид шаардлагатай техник хэрэгслээр хангаж, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилгын өргөтгөлийг барьж ашиглалтад оруулна.
- 1.2.6. Насжилт өндөртэй эрүүл мэндийн төвийн барилгуудыг шинээр барьж, өргөтгөл, их засвар хийнэ.
- 1.2.7. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.
- 1.2.8. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тулгуурлан олон улсын жишигт нийцсэн хавдар судлалын бүсийн төрөлжсөн эмнэлэг байгуулна.
- 1.2.9. Олон улсын жишигт нийцсэн хавдар судлалын бүсийн эмнэлгийг түшиглэн, бүс нутгийн иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, дэвшилтэт технологи болон уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээнд тулгуурласан эрүүл мэндийн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.
- 1.2.10. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй, хурдан шуурхай, хүртээмжтэй болгох менежментийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 1.2.11. Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг 98 хувьд хүргэж хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.
- 1.2.12. Хүнс, эмийн чанар баталгаажуулах өндөр технологит суурилсан лавлагаа лаборатори байгуулж хүнс, эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.
- 1.2.13. Эм, эмнэлгийн хэрэгслийг бүсийн хэмжээнд тогтвортой хүргэх зорилгоор нөөцийн агуулахыг Ховд аймагт байгуулна.
- 1.2.14. Хорт зуршлаас сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.2.15. Багийн эмч нарыг унаажуулна.
- 1.2.16. Баруун бүсийн эмчилгээ оношилгооны төвийг MRI аппараттай болгоно.

- 1.3.14. Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны стандартыг шинэчилж, орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилж, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.
- 1.3.15. Бүх сумдын нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, ариутгах татуургын нэгдсэн системд холбож, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлнэ.
- 1.3.16. “Монгол хүн” бэлтгэх бодлогын хүрээнд уламжлалт боловсрол, төлөвшил хүмүүжил, олон ястны өв соёлын онцлог, амьдрах ухааны онцлогийг тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай уялдуулан заадаг албан бус боловсролын төвийг байгуулна.
- 1.3.17. Бүх нийтийн Монгол бичгийн боловсролыг дэмжиж, хос бичигтэн аймаг болно.
- 1.3.18. Сум, орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлийн багшийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад нь бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.19. Дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их сургуулийн хотхоныг Ховд аймагт байгуулна.
- 1.3.20. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Ховд аймагт дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.
- 1.3.21. Казах үндэстний өв соёлыг бодлогоор дэмжинэ.

Мэдлэг, ур чадвартай төгсөгчид

- 1.3.22. МУИС-ийн Баруун бүсийн сургуулийг түшиглэн бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудыг бодлогоор дэмжиж тэтгэлэг олгоно.
- 1.3.23. МУИС-ийн Баруун бүсийн сургууль, Хөгжил политехник коллежийг хотхон хэлбэрээр хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.3.24. Хөгжил политехник коллежийг түшиглэн баруун бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан “2000 айл” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ур чадвартай гагнуурчин, инженер техникийн мэргэжилтнийг гадаад, дотоодод бэлтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.

1.5. Хүн ам, нийгмийн бүлэг бүрд чиглэсэн хөгжлийн бодлого

Хүүхэд, өсвөр үе, оюутан залуус

1.5.1. МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн оюутны дотуур байрны цогцолборыг шинээр ашиглалтад оруулж, оюутанд ээлтэй дотуур байрыг бий болгоно.

1.5.2. Хөдөлмөрийн хуульд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж, шинэ ажлын байр бий болгох бодлого баримтална.

1.5.3. "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ;
- Төгсөгчдөд зориулан "Хийнгээ суръя - Орлого олъё - Хэмнэе" загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ;
- Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ;
- Оюутны цагаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журмыг сайжруулж нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх, цагийн ажилд зуучлах системийг бий болгоно;
- Бүтэн өнчин оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлж, орон нутгаас дэмжинэ
- Залуучуудыг ажлын байраар хангаж, тасралтгүй суралцах, төрийн албаны залгамж халааг бэлтгэх зорилгоор "Ерөнхий болон тусгай шалгалт"-ын богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна.
- Зах зээлийн эрэлтэй мэргэжлээр гадаад улсад мэргэжил эзэмшихэд бодлогоор дэмжинэ.
- Гарааны бизнес эрхлэгч, инноваци, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор ШАРК ТАНК хөрөнгө оруулалтын реалити нэвтрүүлгийг олон нийтийн оролцоотойгоор хийж хэвшүүлнэ.

1.5.4. "Оюутан цэрэг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж дээд боловсрол эзэмших явцад иргэний журамт үүргээ биелүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.5.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амин дэмийн хэрэгцээг хангах, эрүүл чийрэг иргэн төлөвшүүлэх зорилгоор "СҮҮ" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.5.16. Бүх сумдын эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр ханган, Старлинкийн интернэтэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.

1.5.17. Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

Эхчүүд, эмэгтэйчүүд

1.5.18. Жендерийн тэгш байдлыг хангах хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.

1.5.19. "Цалинтай эх, эцэг" нийгмийн хамгааллын бодлогыг нийгмийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан орон нутагт хэрэгжүүлнэ.

1.5.20. Эхчүүдэд зориулсан төрөлжсөн, мэргэжлийн асрах үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэгтэд нийцүүлэн хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

Эрэгтэйчүүд

1.5.21. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд "Аав, эрчүүд", "Чанартай амьдрал - аавуудын оролцоо", "Эрүүл эр хүн" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.5.22. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5.23. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.5.24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлж дотоодын давуу эрх олгоно.

1.5.25. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг нэвтрүүлж, судалгаанд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

1.5.26. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асрамжийн төвийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд

1.6.8. “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулж, ejob.gov.mn платформоор дамжуулан ажилд зуучлах хөдөлмөрийн яармагийг улирал бүр тогтмол зохион байгуулна.

1.6.9. “Миний түрээсийн орон сууц” дэд хөтөлбөрт зорилтот бүлгийн өрхүүдийг хамруулна.

1.7. Хөдөлмөр эрхлэлт

1.7.1. Шинэ Ховд, Үйлдвэр технологийн парк, Агро парк, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, боомтын сэргэлт, уул уурхайн томоохон төслүүдийг түшиглэн бүсийн хэмжээнд 2500 ажлын байрыг шинээр бий болгоно.

1.7.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гүйцэтгэхдээ орон нутгийн иргэдийг түр болон байнгын ажлын байраар ханган ажилласан байдлыг харгалзан дотоодын давуу эрх олгоно.

1.7.3. Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.7.4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийж, үр дүнд үндэслэн хүний нөөцийг бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах, зуучлах ажлыг цогц байдлаар зохион байгуулна.

1.8. Соёл, урлаг

1.8.1. Үндэсний өв, уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн “ЖАНГАР” олон угсаатны өв соёл дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулна;
- Олон угсаатны өв соёлын наадмуудыг зохион байгуулна;
- Хөөмий, тууль, домбор, уран нугаралт, бий биелгээ зэрэг төрлүүдийг бодлогоор дэмжинэ.

1.8.2. Үндэсний соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж, дэлхий дахинд сурталчлан таниулах замаар баруун Монголын өв соёлын орон зай, үнэ цэнийг өсгөх контент бэлтгэгчдийг дэмжинэ.

1.8.3. Угсаатны соёлын өвийг хадгалан хамгаалах, ондоошлыг илэрхийлсэн “Олон угсаатны урлаг дэлхийн тайзнаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.9.6. “Алдрын түүчээ” үндэсний бөхийн чуулга барилдааныг жил бүр уламжлал болгон Ховд бөхийн дэвжээтэй хамтран зохион байгуулна.
- 1.9.7. Спортын холбоотой хамтран ажиллаж нийтийн биеийн тамир болон мэргэжлийн спортуудыг тэгш хөгжүүлнэ.
- 1.9.8. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын (урбан) спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийг суурин газруудад бүтээн байгуулна.
- 1.9.9. Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудыг түшиглэн шинээр спорт заал барьж, хүүхэд залууст чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэж, эрүүл чийрэг бие бялдартай болоход бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.9.10. Жаргалант сумын бага зааланд их засвар хийж иргэд үйлчлүүлэх ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ.



2.3.4. Бага оврын нефть боловсруулах үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

2.4. Боомтын сэргэлт, бүс холбосон зам, тээвэр, логистик

2.4.1. Мянганы замын Ховдын Мянгад-Завханы Загастайн давааны арын уулзвар чиглэлийн 426 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.2. Мянганы замын Ховдын Мянгад-Хонгиогийн гүүр хүргэлх 32 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.3. Ховд – Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.4. Босоо, хэвтээ тэнхлэгийн замын огтлолцлыг түшиглэн хуурай боомтыг байгуулна.

2.4.5. Ховд Нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөл хийнэ.

2.4.6. Евро-Азийг холбосон хамгийн дөт зам Шивээхүрэн боомт - Арцсуурь боомт чиглэлийн баруун босоо тэнхлэгийн 725 км төмөр замыг барина.

2.4.7. Булган, Байтаг боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, ачаа тээврийн бүртгэл, гаалийн хяналт шалгалтыг автоматжуулж, рентген, камер, автомат хаалга, автомат жин, шинжилгээний төхөөрөмжийг суурилуулан боомтын “Ухаалаг гарц”-ыг бүрэн ашиглалтад оруулна.

2.4.8. Мөнххайрхан, Дуут сумыг аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбож бүх сумаа хатуу хучилттай авто замаар холбосон анхны аймаг болно.

2.4.9. Улс, хот хоорондын ачаа, авто тээврийн мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгон олон улсын жишигт хүргэж иргэд үйлчлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.10. Нийтийн тээврийн үйлчилгээг дэмжин, ухаалаг үйлчилгээг нэвтрүүлж, иргэдэд үйлчлэх тав тухтай байдлыг нэмэгдүүлнэ.

2.4.11. Булган суманд малын эрүүл ахуйн хорио цээрийн бүс байгуулж, мал, махны экспортыг нэмэгдүүлнэ.

2.5. Эрчим хүчний шилжилт

2.5.1. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж, баруун бүс нутгийг хямд өртөгтэй эрчим хүчээр хангана.

2.5.2. Эрдэнэбүрэн – Мянгад - Улиастайн чиглэлийн 220 кВ-ын 468.3 км цахилгаан дамжуулах агаарын шугам татна.

2.6.9. Алтайн нуруу, их нууруудын экосистемд түшиглэсэн адал явдалт, ангийн, угсаатан зүй, хил орчмын болон хил дамнасан, олон угсаатны аялал жуулчлалыг кластер бүсчлэлээр хөгжүүлж, Их нууруудад түшиглэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

2.6.10. Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулна.

2.7. “Шинэ хоршоо” хөдөлгөөн- Хөдөөгийн сэргэлт

2.7.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг орон нутгийн хэмжээнд өрнүүлж, хоршоологчдыг дэмжинэ.

2.7.2. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг бүрдүүлнэ.

2.7.3. Агро парк, Шинэ хөдөө төслийн хүрээнд худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг түтээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.7.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дутагдалтай байгаа малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэхэд орон нутаг бодлогоор дэмжинэ.

2.7.5. Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

2.7.6. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байр бий болгох бодлогыг сум бүрд хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

2.7.7. Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдыг бодлогоор дэмжинэ.

2.7.8. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон салбар болгон хөгжүүлнэ.

2.7.9. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.7.10. Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлана.

2.7.11. Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг байгуулна.

Эрүүл хүнс

- 2.7.23. Тарвас, Булганы алимыг газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр баталгаажуулж экспортын брэнд бүтээгдэхүүн болгоно.
- 2.7.24. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.
- 2.7.25. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, стандартыг нэмэгдүүлж, эрүүл, чанартай хүнс хэрэглэх тогтолцоог сайжруулна.
- 2.7.26. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар орон нутгийн малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.
- 2.7.27. Баруун бүсийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулж иргэдийн хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.



ДӨРӨВ. ТӨРИЙН БҮТЭЭМЖ БА ЦАХИМ ЗАСАГЛАЛ

4.1. Цахим засаглал

- 4.1.1. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар иргэдийн хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "ухаалаг E-Mongolia" системийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах замаар төрийн үйлчилгээг иргэдэд ээлтэй, хурдан шуурхай болгох ажлыг чанарын шинэ шатанд гаргана.
- 4.1.2. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүний оролцоогүй болгох дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.1.3. Төрийн үйлчилгээний 24 цагийн цахим төвийг бүх сумдад байгуулна.
- 4.1.4. Олон улсын цахим төлбөрийн системүүдийг нэвтрүүлж, төлбөр тооцоог саадгүй хүлээн авах боломжийг орон нутагтаа бүрдүүлэн цахим худалдааг дэмжинэ.
- 4.1.5. Мэдээлэл технологийн салбарын инженерүүдийг бэлтгэх, чадавхжуулах бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.1.6. Баруун бүсийн дата төвийг Ховд аймагт байгуулна.
- 4.1.7. Хур-Дан төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 4.1.8. Invest Khovd, My Khovd, Visit Khovd төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн үйл ажиллагааг өргөтгөнө.
- 4.1.9. Интернэтийн 5G сүлжээг бүрэн нэвтрүүлнэ.

5.3. Үнэт баялаг ус

- 5.3.1. Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.
- 5.3.2. Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, саарал ус ашигладаг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 5.3.3. Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, үйлдвэрлэлийн ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.3.4. Суурин газруудын ундны усан хангамжийн эх үүсвэрийг бий болгож, ухаалаг систем нэвтрүүлж тоолууржуулна.
- 5.3.5. Усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлнэ.

5.4. Ногоон эдийн засгийн шилжилт

- 5.4.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж 20 сая мод тарьж, ургуулна.
- 5.4.2. Ногоон хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжийн удирдлага, бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.4.3. Хөг хаягдлын дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэр барина.
- 5.4.4. Ухаалаг, хэмнэлттэй хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 5.4.5. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц, дэд бүтцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.4.6. Сумдыг бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, эдийн засгийн тэргүүлэх салбарыг кластерын системээр хөгжүүлэх бодлого баримтална.

АЛТАЙ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд өргөтгөл хийж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Боомын амын услалтын системийг бүрэн дуусгана.
3. Эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдоно.
4. Ардын өргөө барина.
5. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
6. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
7. "Алтайн улаан ямаа" үүлдрийн цөм сүргийг сэргээнэ.
8. Барлаг чиглэл рүү явах Бодонч гол дээр бетонон гүүр барина.
9. Барлаг, Алтангадас багийн төвийг дайран өнгөрч байгаа ЦДАШ-наас салбарлаж 0.4 квтын шугам татна.
10. Зуслан, өвөлжөөний бүс цутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
11. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
12. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

БУЛГАН СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээний өргөтгөлийг хийж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. "Байтаг Богд" боомт хот болгон хөгжүүлнэ.
3. Байтаг, Булган боомтын өргөтгөл хийгдэнэ.
4. Ардын өргөө барина.
5. Малын эрүүл ахуй, хорио цээрийн бүс байгуулна.
6. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
7. Булганы алимыг газар зүйн заалттай болгоно.
8. Сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
9. Төвлөрсөн цахилгаан, эрчим хүчний системд холбоно.
10. Нийтийн төвлөрсөн халуун ус барина.
11. Авто зогсоол болон явган хүн, дугуйн замыг барина.
12. Эрчим хүчний 0.4 шугам трансформатор 5 чиглэлд татаж хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
13. Жимс жимсгэнэ хөтөлбөр хэрэгжүүлнэ.
14. Хөдөөгийн зарим багийг цахилгаан эрчим хүчний шугамд холбоно.
15. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төслийг хэрэгжүүлнэ.

8. Музей, номын сангийн барилгын цогцолборыг бүрэн дуусгана.
9. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
10. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
11. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
12. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ДУУТ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбоно.
3. Цэцэрлэгийн барилгыг шинээр барина.
4. Ардын өргөө барина.
5. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
6. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
7. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
10. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ДӨРГӨН СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны эх үүсвэрийг бий болгоно.
3. Ардын өргөө барина.
4. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
5. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
6. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
7. Мянгадаас Дөргөн хүртэлх 41 км хатуу хучилттай замыг бүрэн ашиглалтад оруулна.

142

11. Ойрад Монголын соёл мэдээллийн төв байгуулна.
12. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
13. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
14. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

МӨСТ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир ус, дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
4. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
5. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
6. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
7. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
8. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

МӨНХХАЙРХАН СУМ

8417143092
ПНД АС073 8068454

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбоно.
6. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
7. Мөнххайрхан уулыг түшиглэсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулна.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
10. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ЦЭЦЭГ СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. Ардын өргөө барина.
3. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
4. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
5. Баян-Овоо, Хажинга багт хөв цөөрөм байгуулж, тэжээлийн ургамал, хадлангийн нэгдсэн талбай байгуулна.
6. Цахилгааны хүчдэлийн алдагдлыг бууруулж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөнүүдийг өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
7. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг бүрэн дуусгана.
10. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
11. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ХОВД СУМ

1. Сумын төвийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, иргэдийн ая тухтай орчинд амьдрах, орон сууцжуулах суурь дэд бүтцийг бий болгоно.
2. 12-60 айлын орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
3. Ардын өргөө барина.
4. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төсөл хэрэгжүүлнэ.
5. Сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, кофе шоп, номын сан, хөл бөмбөгийн талбай зэрэг хүүхэд, залуусын хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
6. Цэцэрлэгийн барилга шинээр барина.
7. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр барина.
8. Зуслан, өвөлжөөний бүс нутаг, багийн төвүүдэд үүрэн холбооны сүлжээ тавина.
9. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
10. Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ШИНЭ ХОВД ХОТ

7.1.Хот төлөвлөлт, хотын стандарт

- 7.1.1. Насжилт өндөртэй 12 айл, 24 айл, 36 айл зэрэг орон сууцуудыг иргэдийн оролцоотойгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дахин төлөвлөлт хийж байгаль орчин, иргэндээ ээлтэй ногоон хорооллыг бий болгоно.
- 7.1.2. Жаргалант сумын шаардлагатай байршлуудад хотын стандарт нийцсэн дахин болон хэсэгчилсэн төлөвлөлт хийнэ.
- 7.1.3. Шинэ суурьшлын бүсүүдэд авто зам, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцүүдийг бий болгоно.
- 7.1.4. Ховд хотын хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах ундны усны хоёрдох эх үүсвэрийг бий болгоно.
- 7.1.5. Шинэ дулааны станцын өргөтгөлийг бүрэн дуусгаж дулаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 7.1.6. "Бадамлах дөл" дулааны станцын хэрэглэгч айл өрхийн дулаан хангамжийг сайжруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.
- 7.1.7. Баруун бүсийн KHOVD PALACE спортын цогцолбор, Жаргалант сумын ЖАНГАР соёлын ордон, Баруун бүсийн эрдэм шинжилгээний төв, Баруун бүсийн эмчилгээ оношилгооны төвийн өргөтгөл, МУИС-ийн баруун бүсийн сургуулийн оюутны дотуур байр, номын сангийн цогцолбор, шинэ суурьшлын бүсэд сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгуудыг барина.
- 7.1.8. Ховд хотын авто зам, замын байгууламжид бүрэн шинэчлэл, өргөтгөл, засвар хийнэ.

7.2.Орон сууц ба гэр хороолол

- 7.2.1. Шинээр баригдсан орон сууцны хорооллуудын гадна тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол, тоглоомын талбай зэргийг аж ахуй нэгжүүдтэй хамтран бий болгож иргэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 7.2.2. Дэвшилтэт технологи, шинэ стандартад нийцүүлэн хуучин орон сууц, барилга байгууламжийн гадна фасад, дээвэр засварлаж, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 7.2.3. Ундны усны шугамыг зэс хоолойгоор солих судалгаа хийж, усны зэвийг арилгах зорилгоор цэвэр усны шугамыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.
- 7.2.4. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төслийг үргэлжлүүлэн гэр хорооллын утааг багасгаж, нүхэн жорлонгийн тоог цөөрүүлж, хөрсний бохирдлыг бууруулах стандарт, нөхөн сэргээх, ногоон байгууламжуудыг бий болгох ажлыг цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.
- 7.2.5. Ногоон зээлийн санхүүжилтээр олон улсын байгууллагатай хамтран хашаа бүрд өрхийн нарны дэлгэц, цахилгаан хураагуур, халаалтын системийн

7.4.7. Ховд хотын орон сууцнуудад ухаалаг хаалга суулгаж, ухаалаг орцтой болгоно.

7.5. Хотын эдийн засаг

7.5.1. 1000 тонн нарийн ногоо хураах өвлийн хүлэмжийн кластер бүхий тусгай бүсийг байгуулж “Агропарк” цогцолборыг бүрэн дуусгана.

7.5.2. “ШИНЭ ХОВД” , “Агро парк” хөнгөн үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалтыг бүрэн дуусгана.

7.5.3. “Эко парк” хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдал ангилан ялгаж, хүлээн авах цэг байгуулна. Жилд дунджаар 60 мян.тн хог хаягдал төвлөрсөн хогийн цэгт булшилж байна. Үүний 30-40 хувийг дахин боловсруулах боломжтой байдаг.

7.5.4. Эртний түүхт Ховд хот аялал жуулчлалын хөтөлбөр гаргаж аялал жуулчлалын салбараас орж ирэх орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

7.5.5. Баруун бүсийн хүүхдийн паркийн үйл ажиллагааг өргөтгөж, жилийн дөрвөн улирал ажиллуулж, бүсийн соёл амралтын цогцолбор болгон эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

7.6.Хотын дэд бүтэц

7.6.1. Авто замын ус зайлуулах суваг хоолой, үсрийн даланг барьж байгуулна.

7.6.2. Ховд хотын хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцүүлэн бохир усны дэд станц, шугам хоолойг шинэчилж цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

7.6.3. Ховд хотын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 К.в болгож, хүчдэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн зарим дэд станцыг өргөтгөнө.

7.6.4. Хотын газар доорх инженерийн дэд бүтцийн байгууламжийн шинэчлэлийг үе шаттайгаар бүрэн шинэчилнэ.

8.3.4. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, боловсролын түвшин дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

8.3.5. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, орон нутгийн төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ.

8.4. Амар тайван орчин

8.4.1. “Авлига - хүнд сурталгүй” аймаг болох зорилтоо цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн албаны бүх шатанд хариуцлага, сахилга бат, соёлтой боловсон харилцааг нэвтрүүлж ил, тод, нээлттэй төрийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

8.4.2. Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн ногоон бүс бүхий анхны аймаг болно.



---000---

**ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

"ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН БОДЛОГО"

Сумын Засаг даргаас бүрэн эрхийн хугацаанд хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН БОДЛОГО" сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа:

Иргэдийнхээ эрх ашгийг нь дээдлэн, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг удирдлага болгон;

"Алсын хараа-2050" урт хугацааны хөтөлбөр, "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль" "Шинэ сэргэлтийн бодлого" "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хөгжлийн тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин;

Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Хүний хөгжлийг эрхэмлэсэн нийгмийн тогтолцоотой, баялаг бүтээгчдийг дэмжсэн бизнест ээлтэй өөрийгөө тэтгэсэн эдийн засагтай, хөдөө аж ахуйн хөгжлийг шинэ шатанд гаргасан, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлоготой, байгаль орчинд ээлтэй сум болох зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон Хүний хөгжлийн бодлого, Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого, Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн хөгжлийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого, байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого гэсэн 5 бүлэгтэй 7 зорилтыг 34 чиглэл 180 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа.

1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүний хөгжлийг дэмжиж, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, эрдэм боловсролтой, эрүүл хүнийг хөгжүүлнэ.

1.1. Гэр бүл, хүүхэд, оюутан залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн. Гэр бүл

1.1.1. "Монгол гэр бүл" төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, гэр бүлийн хөгжлийг дэмжинэ.

1.1.2. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.3. Залуу малчин гэр бүлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.

Хүүхэд

1.1.4. Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулна.

1.1.5. Хүүхдийг болзошгүй эрсдэл, цахим гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.

1.1.6. Хүүхэд харах, өдөр өнжүүлэх үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.1.7. Өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын төсөл арга хэмжээ хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

1.1.8. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.

1.1.9. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, хөгжих боломжийг бүрдүүлнэ.

1.1.10. Бага насны хүүхдэд шим тэжээлийн дэмжлэг үзүүлэх төсөл хэмжээ хэрэгжүүлнэ.

Оюутан, залуучуудын хөгжил

1.1.11. Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих "Залуусын оролцоо" төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн /тусгай хэрэгцээт иргэн/

1.1.12. "Бэрх биш ээлтэй" төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ахмад настан

1.1.14. Ахмад настны хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ.

Жендерийн эрх тэгш байдал

1.1.15. Төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх салбарт жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.

Эхчүүд, эмэгтэйчүүд

1.1.16. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.1.17. "Эмэгтэйчүүдийн манлайлал" төсөл арга хэмжээ хэрэгжүүлнэ.

1.2. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал

Ажилтай орлоготой иргэнийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулж, хүний нөөцийн асуудлыг бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ.

1.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлнэ.

1.2.2 Тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжинэ.

1.2.3 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, сайн дурын даатгалын хамрах хүрээг өргөтгөх, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

1.2.4 Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.

1.3 Боловсрол

Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, бүх шатны боловсролын сургалтын байгууллагад цахим орчныг бүрдүүлж, багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжинэ.

1.3.1 Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сургалтын орчин, чанар, хүртээмжийг сайжруулж, сурагчид орчин үеийн боловсролыг хүртэх боломжийг бүрдүүлнэ.

1.3.2 Мэргэжлийн байгууллагатай хамтран боловсролын чанарын үнэлгээг ерөнхий боловсролын сургуулийн багш нар, төгсөх ангийн сурагчдын хүрээнд 2 жилд нэг удаа зохион байгуулж, хот болон хөдөө орон нутгийн сургуульд суралцагчдын дундаж онооны зөрүүг үе шаттай бууруулна.

1.3.3 Хүүхдийн шинжлэх ухаанч, техник сэтгэлгээг хөгжүүлэх STEM төслийг сургалтын хөтөлбөртэй уялдуулан бага, дунд, ахлах ангид үе шаттай хэрэгжүүлж, хүүхдүүд зөвхөн шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик салбарын мэдлэгтэй болохоос гадна бүтээлч чадвар, сэтгэхүйг хөгжүүлнэ.

1.3.4 “Эх оронч-Монгол хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлж, ёс заншлаа дээдэлдэг, эх орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёлоор бахархдаг өөртөө итгэлтэй, бүтээлч иргэн төлөвшүүлнэ.

1.3.5 “Чадварлаг багш, сурагч” /багш, сурагч, удирдлага, ажилчдыг урамшуулах/ төсөл хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлснээр сургалтын чанарыг сайжруулахад чухал хувь нэмэр оруулж, хүүхдүүдийн боловсролд эерэг өөрчлөлтийг бодитоор бий болгоно.

1.3.6 Сургууль, Цэцэрлэгийг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн анги танхим бүрийг орчин үеийн ухаалаг самбар, chromebook бүхий орчин үеийн цахим танхимтай болгож, дотуур байранд chromebookтэй, ухаалаг самбартай цахим орчныг бүрдүүлэн, цахимжсан боловсролыг чанартай эзэмшүүлэх нөхцөлийг хангана.

1.3.7 Математик, англи хэлний мэдлэг, чадвар олгох EDUTEN, PEARSON болон бусад цахим платформуудын ашиглалтыг сайжруулж, суралцагчдын математик, англи хэлний мэдлэгийг гүнзгийрүүлж, боловсролын ялгаатай байдлыг арилгана.

1.3.8 Ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт бүрэн хамруулж, хоолны шим тэжээлийг сайжруулан, сурагчдын эрүүл мэнд, өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.4 Үндэсний бахархал, соёлын өв:

1.4.1 Мягад-Дөрвөд ардын уртын дууны наадмыг 2 жилд 1 удаа зохион байгуулж явуулна.

1.4.2 Бүх нийтээр хос бичигтэн болох бодлогыг дэмжин үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгжилтийг хангаж ажиллах.

1.4.3 Соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадавхжуулж мэргэжлийн уран бүтээлчдийг дэмжин ажиллана.

1.4.4 Угсаатны уламжлал соёл урлагийг сурталчлан таниулах аялал жуулчлалын арга хэмжээнүүдэд бэлтгэн оролцоно. /Мөнгөлөг шагшурга, Цайны зам бусад гэх мэт

1.5 Аялал жуулчлал:

1.5.1 Байгалийн болон соёлын аялал жуулчлалыг нутгийн иргэдэд түшиглэн хөгжүүлэх цогц төслийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.5.2 Орон нутгийн онцлогт тохирсон иргэдийн амрах чөлөөт бүс, амралт чөлөөт цагийн парк байгуулж, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.5.3 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй, нэгжийн үйл ажиллагааг дэмжин газар олгож дэд бүтцийн чиглэлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

1.6 Биеийн тамир, спорт

1.6.1 Орон нутагт спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх "Спортын аварга" төсөл арга хэмжээ, урамшууллын журмыг шинэчлэн боловсруулж үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.6.2 Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл амьдралын дадал хэвшлийг суулгах зорилгоор улирлын спортыг хөгжүүлж, нийтийн биеийн тамирыг өргөжүүлнэ.

1.6.3 Биеийн тамир, спортын салбарын хүний нөөц, материаллаг баазыг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ.

1.7 Эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэнд

1.7.1 Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг нэмэгдүүлнэ.

1.7.2 Эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн эндэгдлийн шалтгаан болж буй эрсдэлээс урьдчилан сэргийлж болох осол гэмтлийг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж, нийт эндэгдлийг бууруулна.

1.7.3 Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих "Эрүүл, чийрэг хүүхэд" төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.7.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, дэмжих урамшуулах, хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд чиглэсэн "Чадварлаг эмч, мэргэжилтэн" төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.7.5 Мэргэжлийн шүдний эмчээр хангагдаж, шүдний өвчлөлийг бууруулж эрүүл шүдтэй сум болно.

2. ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЭЦ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, жижиг, дунд, хөнгөн үйлдвэрүүд хөгжсөн, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлана

2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил

2.1.1 Орон нутгийн татварын хувь хэмжээг оновчтой тогтоох, татварын бааз, суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.1.2 Төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлж, санхүүгийн сахилга, хариуцлагыг эрс дээшлүүлэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангана.

2.1.3 Худалдан авах ажиллагааг ил тод болгож, аж ахуйн нэгж, байгууллагуудыг өрсөлдөх тэгш боломжоор ханган, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, дүгнэж тайлагнана.

2.1.4 Бүртгэл санхүүгийн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэн сайжруулж "Цахим санхүү"-ийн үйл ажиллагааг тасралтгүй явуулна.

2.1.5 Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санг иргэдэд ил тод нээлттэй, цахим шилэн болгоно.

2.1.6 Орон нутгийн төсөв, төслийг шийдвэрлэхэд иргэдийн санал хүсэлтийг эрэмбэлэн тусгаж шууд оролцох боломжийг бүрэн хангаж ажиллана.

2.1.7 Сумын өмч хамгаалах зөвлөл нь хагас, бүтэн жилээр байгууллагуудын хөрөнгө тоолох комиссын саналыг үндэслэн хөрөнгө авах, актлах ажиллагааг журмын хүрээнд шийдвэрлэж ажиллана.

2.1.8 Байгууллагын дотоод хяналтын ажлын хэсгийг байгуулж санхүүгийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт тавьж ажиллана.

2.1.9 Статистикийн тооллого судалгааг хагас, бүтэн жилээр хууль журмын хүрээнд явуулна.

2.2 Баялаг бүтээгч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг дэмжих

2.2.1 Төр, хувийн хэвшлийн түншлэл, төрийн бус байгууллагын харилцааг өргөжүүлэн, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг нэмэгдүүлнэ.

2.3 Уул уурхай, хүнд үйлдвэрлэл

2.3.1 Орон нутагт хийгдэж буй ашигт малтмалын геологийн судалгаа, хайгуулын ажил, эрдэс баялгийг нээж илрүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг орон нутгийн зүгээс дэмжинэ.

2.3.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын хайгуул судалгааг бодлогоор дэмжиж, барилгын материал, үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлнэ.

2.3.3 Олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, орон нутгийн хамтран ажиллах гэрээг холбогдох хууль журамд нийцүүлэн байгуулж, хамтран ажиллана.

2.3.4 Баялгийн шийдвэрт иргэдийн оролцоог хангана.

2.3.5 Уул уурхайн лиценз олголтын асуудлыг олон нийтэд нээлттэй мэдээллэж, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох ажлыг шийдвэрлэнэ.

2.4 Газар зохион байгуулалт, газрын харилцаа

2.4.1 Сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг зохион байгуулна.

2.4.2 Сумын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийж хэрэгжүүлнэ.

2.4.3 Газрын харилцааны цахим шилжилтийн ажлыг эрчимжүүлнэ.

2.4.4 Нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлах гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах болон хаягийн тэмдэг, тэмдэглэгээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулна.

2.4.5 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн хилийн цэсийг тодотгоно.

2.4.6 Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж зөрчлийг арилгана.

2.5 Хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжил

2.5.1 Сумын төвийн 450 метрийн урттай цементэн хучилттай замыг барина.

2.5.2 Сургуулийн үүдний эко шал шинээр хийнэ.

2.5.3 Хот Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийж, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлуулна.

2.5.4 Ерөнхий боловсролын сургуульд их засвар хийнэ.

2.5.5 Мянгад суманд баригдах ус хангамжийн системийн барилга барина.

2.5.6 Цагаанбулан багийн төвийн барилгын их засвар хийнэ.

2.5.7 Ковш худалдан авна.

2.5.8 Ариутгалын ДУК машин худалдан авна.

2.5.9 Цагдаагийн машины техник хэрэгсэл шинэчилнэ.

2.5.10 Төмөр боловсруулах үйлдвэр барина.

2.5.11 Спорт цогцолбор барина.

2.5.12 Газар доорх инженерийн шугам сүлжээ шинэчилнэ.

2.5.13 Услалтын систем байгуулна.

2.5.14 Цагаанбулан багт бетон гүүр шинээр барина.

2.5.15 Нутгийн удирдлагын ордон шинээр барина.

2.5.16 8-12 айлын орон сууц барьж ашиглалтад оруулна.

2.5.17 Засаг даргын Тамгын газрын авто машины парк шинэчилнэ.

2.5.18 Засаг даргын Тамгын газрын их засвар хийнэ.

2.5.19 Хуучин цэцэрлэгийн барилгыг засаж тохижуулна.

2.5.20 Багуудын төв болон өргөөний дулаан хангамж, тохижилтыг сайжруулна.

2.5.21 Дулааны станц шинээр барих

2.5.22 Цахилгааны шугам өргөтгөл хийнэ.

3. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг дэмжинэ.

3.1 Мал аж ахуй

3.1.1 Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, гойд ашиг шимт мал болон цөм сүргээс үржлийн мал бойжуулж, малын генийн санг хамгаалах

3.1.2 Малчны тухай хууль, малчны хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.1.3 Залуу малчдын мэдлэг чадварыг сайжруулах

3.1.4 "Малчдыг сонсох өдөр", "Үзэсгэлэн худалдаа" арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

3.1.5 Бог малын хээлтүүлэгчийг бүрэн зэмэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.1.6 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, булаг шандын эх ундарга сэргээж хашиж хамгаалах, худаг уст цэгийг шинээр барих, засварлах.

3.2 Газар тариалан

3.2.1 Усалгаатай газар тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлж малын тэжээлийн ургамал тариалалтыг дэмжинэ.

3.2.2 Хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг дэмжиж, хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангана.

3.2.3 Жимс, жимсгэнийн аж ахуйг дэмжиж, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж, төсөл хөтөлбөрүүдэд хамруулна.

3.2.4 Тариаланчдын зөвлөгөөнийг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

3.3 Мал эмнэлэг

3.3.1 Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн /мах сүү, өндөг/-нд эмийн бодисын үлдэгдэл илрүүлэх, бичил биетний тэсвэржилтийг тогтоох шинжилгээг жил бүр хийнэ.

3.3.2 Гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.

3.3.3 Хүн мал амьтны халдварт эрөнз, өвчин тархах эрсдэлээс сэргийлэх, Байгаль орчны цэвэрлэгээ сэг зэм устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулна.

3.3.4 Мал амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулж, нэвтрэн өнгөрч буй мал, амьтны бүртгэл, мэдээллийн сан бий болгоно.

3.4 Үйлдвэрлэлийг хөгжүүлэх

3.4.1 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдэд бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

3.4.2 "Ховдод үйлдвэрлэв төв" өөр дамжуулан бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн борлуулалтыг бодлогоор дэмжинэ.

3.4.3 "Мянгад брэнд" бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг бүх талаар дэмжиж сум орон нутгийн онцлогт тохирсон брэндийг бий болгох баялаг бүтээгч, шинэ брэнд бий болгосон иргэн, аж ахуй нэгжийг дэмжинэ.

4. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Хүний эрхийг дээдэлсэн, авлига, хүнд сурталгүй, чадварлаг, ухаалаг төрийн албыг бэхжүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулан чанар, хүртээмж, үр дүн, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

4.1 Хүний эрхийг дээдэлсэн чадварлаг төрийн алба

4.1.1 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулж, төрийн үйлчилгээг соёлтой, хүртээмжтэй, шуурхай, хүнд сурталгүй хүргэх нөхцөл бүрдүүлнэ.

4.1.2 Архивын баримтын хадгалалт хамгаалалтын орчин, нөхцөлийг сайжруулна.

4.1.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг чадавхжуулна.

4.1.4 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдлыг цаасаар болон цахимаар хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажиллана.

4.1.5 Архивын тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг хэрэгжүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

4.1.6 Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлын хүрээнд Монгол бичгээр унших, бичих, компьютерт шивэх бүрэн чадамжтай албан хаагчдыг бэлтгэх сургалтад хамруулна.

4.1.7 Албан байгууллагууд өөрсдийн баримтыг тусдаа архивладаг болох журмыг хэрэгжүүлэх. Хөмрөг үүсгэгч байгууллагын жагсаалт шинэчлэгдэх, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явагдахтай холбоотой мэдээ, мэдээлэл сургалт зохион байгуулна.

4.1.8 Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, цахим орчны зохистой хэрэглээг хэвшүүлэх, мэдээллийн технологийн мэргэшүүлэх чиглэлээр сургагч багшийг бэлтгэж, сургалт зохион байгуулна.

4.2 Цахим төрийн үйлчилгээ

4.2.1 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын мэдээлэл солилцооны нэгдсэн сүлжээг өргөтгөн ажлын уялдаа холбоог сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

4.2.2 Хөдөөгийн алслагдсан Баянбулаг багт харилцаа холбооны үйлчилгээ хүргэх зорилгоор хэрэгжүүлж буй газрын зөвшөөрлийг шуурхай олгож, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагад санал хүсэлтийг уламжилна.

4.2.3 Төрийн байгууллагад хандсан иргэдийн цахим өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажиллана.

4.3 Төрийн албаны шинэчлэл

4.3.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, удирдах албан хаагчдын ажлын тайлангийн нээлттэй сонсголыг жил бүр зохион байгуулж, сахилга, хариуцлагыг сайжруулна.

4.3.3 Төрийн албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.

4.3.4 Баг байгууллагын үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа явцын болон гүйцэтгэлийн үнэлгээ хийж зөвлөн туслах, үнэлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.4 Гавъяат үйлстнийг алдаршуулах дурсгалыг мөнхжүүлэх

4.4.1 Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, хувьсгалт тэмцлийн нэрт зүтгэлтэн, ахмад дайчдын 110, 120 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.

4.5 Тэгш ой, тэмдэглэлт өдрүүд

4.5.1 Төрийн тахилгат Алтан Хөхий хайрхны тэнгэрийг тайх ёслолын арга хэмжээг зохион байгуулна.

4.5.2 Мянгад сумын Өсөх нахиа цэцэрлэгийн 60 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлнэ.

4.6 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

4.6.1 Сумын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хуулиар зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана.

4.7 Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах

4.7.1 Батлан хамгаалах бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавьж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг хуульд заасан үечлэлээр зохион байгуулан, бэлтгэлжилтийг дээшлүүлнэ.

4.7.2 Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэхэд шаардагдах материаллаг нөөцийг бүрдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

4.7.3 Эх оронч хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.

4.8 Гамшгийн үеийн бэлэн байдал

4.8.1 Сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний хүний нөөцийн болон техникийн чадавхыг нэмэгдүүлж, болзошгүй гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга ажиллагааны орчин нөхцөлийг сайжруулна.

4.8.2 Гамшгийн үеийн эрсдэлийн менежментийг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхыг бүрдүүлнэ.

4.9 Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх болон хууль сахиулах үйл ажиллагаа

4.9.1 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.9.2 Шинээр батлагдсан хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор зөвлөгөө, туслалцаа үзүүлэх "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг улиралд нэг удаа зохион байгуулна.

4.9.3 Сумын нутаг дэвсгэрт зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

5 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүрээлэн буй орныг хамгаалах, бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

5.1 Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

5.1.1 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сум суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.1.2 Сумын төвийн ундны усны худгуудыг тоолууржуулан, тохижуулж, айл өрхүүдийг картжуулах ажлыг үе шаттайгаар хийнэ.

5.2 Агаар, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах

- 5.2.1 Жил бүр агаар, орчны бохирдуулагч эх үүсвэрийн тооллого судалгаа хийнэ.
- 5.2.2 Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байхаар оновчтой менежментийг хэрэгжүүлнэ.
- 5.2.3 Сумын төвлөрсөн хогийн цэгийн хогийг түрж, тэгшлэн хэмжээг багасган, шинээр хогийн цэг байгуулан хашаажуулна.
- 5.2.4 Бүх нийтийн цэвэрлэгээг хавар намрын улиралд зохион байгуулан, жилд 1 удаа золбин нохой устгана.

---oOo---



184

Ховд аймгийн Монгол Ардын Намын хорооны
Тэргүүлэгчдийн 2024 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**ХОВД АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ
ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2024.06.24

УРИА: БҮСИЙН ХӨГЖЛИЙГ

ХОВДЧУУД МАНЛАЙЛНА



НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орон сууц

- 1.1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эхний гурван жилд 3 хувийн хүүтэй, ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, "2000 айл" орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Ховд аймагт шилжин суурьшиж буй иргэд, залуу гэр бүл, оюутан залууст зориулан түрээслэх, түрээслээд өмчлөх "Миний түрээсийн орон сууц" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.3. Сумын төвүүдэд 12-60 айлын орон сууц барина.
- 1.1.4. "Хашаандаа сайхан амьдарцгаая Ховдчуудаа" төслийг аймаг, сумын төвүүдэд хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих эко зээлд хамруулна.
- 1.1.5. Төрийн албан хаагчид болон ажигтандаа орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх "Миний ажигтан орон сууцтай" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2. Эрүүл мэнд

- 1.2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн явуулын багийг сум бүрд жилдээ 3-4 удаа тогтмол ажиллуулж, хүн амын дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.2.2. Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн хувийг 50, умайн хүүзүүний хавдрын эрт илрүүлгийг 68 хувьд хүргэж, эмэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдох хавдрын өвчлөл, хүүхдийн эндэгдлийг бууруулна.
- 1.2.3. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн бисийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.
- 1.2.4. "Чадварлаг эмч, мэргэжилтэн" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Орон нутагт хэрэгцээтэй нарийн мэргэжлээр суралцаж байгаа эмч, эмнэлгийн ажилтныг дэмжин тэтгэлэг олгоно.
 - Орон нутагт нарийн мэс ажилбарыг амжилттай нутагшуулж буй эмч, мэргэжилтнүүдийг урамшуулна.
 - Хөдөө сумдад олон жил тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийг урамшуулна.

- Суманд нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг сумандаа ирж ажиллахад орон сууцны дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.5. Эрүүл мэндийн яаралтай тусламжид шаардлагатай техник хэрэгслээр хангаж, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилгын өргөтгөлийг барьж ашиглалтад оруулна.
- 1.2.6. Насжилт өндөртэй эрүүл мэндийн төвийн барилгуудыг шинээр барьж, өргөтгөл, их засвар хийнэ.
- 1.2.7. “Эдэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.
- 1.2.8. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тулгуурлан олон улсын жишигт нийцсэн хавдар судлалын бүсийн төрөлжсөн эмнэлэг байгуулна.
- 1.2.9. Олон улсын жишигт нийцсэн хавдар судлалын бүсийн эмнэлгийг түшиглэн, бүс нутгийн иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, дэвшилтэт технологи болон уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээнд тулгуурласан эрүүл мэндийн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.
- 1.2.10. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй, хурдан шуурхай, хүртээмжтэй болгох менежментийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 1.2.11. Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг 98 хувьд хүргэж хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.
- 1.2.12. Хүнс, эмийн чанар баталгаажуулах өндөр технологит суурилсан лавлагаа лаборатори байгуулж хүнс, эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.
- 1.2.13. Эм, эмнэлгийн хэрэгслийг бүсийн хэмжээнд тогтвортой хүргэх зорилгоор нөөцийн агуулахыг Ховд аймагт байгуулна.
- 1.2.14. Хорт зуршлаас сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.2.15. Багийн эмч нарыг унаажуулна.
- 1.2.16. Баруун бүсийн эмчилгээ оношилгооны төвийг MRI аппараттай болгоно.

1.3. Боловсрол

- 1.3.1. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.3.2. Хүн амын нягтаршил, өсөлт, газар зүйн онцлог, хүртээмжид үндэслэн шинэ суурьшлын бүсэд 960 хүүхдийн багтаамжтай ерөнхий боловсролын VIII сургуулийг барина.
- 1.3.3. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ шаардлагатай сум, багуудад цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 1.3.4. Жаргалант сумын XI цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ.
- 1.3.5. Жаргалант сумын III сургуульд их засвар хийнэ.
- 1.3.6. Олон улсын төрөлжсөн хөтөлбөр бүхий гүнзгийрүүлсэн сургалттай хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын сургууль байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.7. Боловсролын тухай хуульд англи хэлийг үндсэн гадаад хэлээр тодорхойлсны дагуу бүх шатны сургалтын байгууллагын сурагцагч англи хэлийг эзэмших тэгш боломж бүрдүүлж, англи хэлийн 30 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх боломжоор хангана.
- 1.3.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн үйл ажиллагаанд түшиглэн боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн сурагцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
- 1.3.9. Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээл, STEM, EDUTEN хөтөлбөрийг хэрэгжүүлэх лаборатори байгуулна.
- 1.3.10. МУИС-ийн Баруун бүсийн сургуулийг түшиглэн баруун бүсийн судалгааны төвийг байгуулж, инновацийн бүтээл гаргах, хэрэглээнд нэвтрүүлэх, инновацийн экосистемийг бий болгож, үр өгөөжтэй технологи боловсруулна.
- 1.3.11. Насан туршийн боловсролын төвийн оффисын байранд их засвар хийж, сургалт явуулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.12. Боловсролын байгууллагын хичээллэх болон амралтын хугацааг байгаль цаг уур, үндэсний соёл, өв уламжлал, амьдралын хэв шинж, ахуйд нийцүүлнэ.
- 1.3.13. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулсан ногоон бүс үйл ажиллагааг үргэлжлүүлэн хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

- 1.3.14. Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны стандартыг шинэчилж, орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилж, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.
- 1.3.15. Бүх сумдын нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, ариутгах татуургын нэгдсэн системд холбож, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлнэ.
- 1.3.16. “Монгол хүн” бэлтгэх бодлогын хүрээнд уламжлалт боловсрол, төлөвшил хүмүүжил, олон ястны өв соёлын онцлог, амьдрах ухааны онцлогийг тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай уялдуулан заадаг албан бус боловсролын төвийг байгуулна.
- 1.3.17. Бүх нийтийн Монгол бичгийн боловсролыг дэмжиж, хос бичигтэн аймаг болно.
- 1.3.18. Сум, орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлийн багшийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад нь бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.19. Дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их сургуулийн хотхоныг Ховд аймагт байгуулна.
- 1.3.20. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Ховд аймагт дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.
- 1.3.21. Казах үндэстний өв соёлыг бодлогоор дэмжинэ.

Мэдлэг, ур чадвартай төгсөгчид

- 1.3.22. МУИС-ийн Баруун бүсийн сургуулийг түшиглэн бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудыг бодлогоор дэмжиж тэтгэлэг олгоно.
- 1.3.23. МУИС-ийн Баруун бүсийн сургууль, Хөгжил политехник коллежийг хотхон хэлбэрээр хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.3.24. Хөгжил политехник коллежийг түшиглэн баруун бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан “2000 айл” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ур чадвартай гагнуурчин, инженер техникийн мэргэжилтнийг гадаад, дотоодод бэлтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.

Багшлах хүний нөөц, ур чадвар

1.3.25. "Чадварлаг багш, оюутан, суралцагч" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Багш нарыг гадаад дотоодод мэргэжил дээшлүүлнэ;
- Орон нутагт хэрэгцээтэй мэргэжлээр төрийн өмчийн их дээд сургууль, коллежид амжилттай суралцаж буй 100 оюутанд тэтгэлэг олгоно;
- Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын масс сургалт, гүйцэтгэлийн үнэлгээ, элсэлтийн ерөнхий шалгалт, олимпиад, уралдаан тэмцээнүүдэд амжилт гаргасан багш, анги хамт олон, суралцагчдыг урамшуулж алдаршуулна;
- Докторын зэрэг хамгаалсан орон нутгийн төрийн албан хаагч, иргэдэд урамшуулал олгоно;
- Өндөр ур чадвартай, олон улсын хэмжээнд ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүдийг орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлнэ;
- Багш бүрийг өндөр хүчин чадалтай зөөврийн компьютертой болгоно.
- Массын сургалтад амжилт гаргасан багшийг 40.0 хүртэл сая төгрөгийн урамшуулал олгоно.
- Олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр гадаад улсаас өндөр мэргэжлийн багш нарыг урьж ажиллуулна.

1.3.26. Багшийн хөгжлийн ордонг ашиглалтад оруулж, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт арга зүйн байгууллагын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааг өргөтгөн МУИС-ийн Баруун бүсийн сургуульд түшиглэсэн багшийн хөгжлийн төвийг бий болгож хамтын ажиллагааг дэмжинэ.

1.3.27. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт шаардлагатай хатуу, зөөлөн эдлэлийн шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.

1.3.28. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, их сургууль, коллежийг шаардлагатай орчин үеийн технологи бүхий лаборатори, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

1.3.29. Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.

1.4. Нийгмийн баталгаа

1.4.1. Баялагтаа эзэн Ховд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгалийн баялгийн өгөөжийг иргэн бүрд тэгш хүртээж, айл өрх бүрийн дулаан, цахилгаан, хог, усны талбөрийг төлөх боломжтой "Ховд карт" хэрэглээнд нэвтрүүлнэ.

1.4.2. Ховд аймагт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгох зорилгоор "Инвест Ховд" төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.5. Хүн ам, нийгмийн бүлэг бүрд чиглэсэн хөгжлийн бодлого

Хүүхэд, өсвөр үе, оюутан залуус

- 1.5.1. МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн оюутны дотуур байрны цогцолборыг шинээр ашиглалтад оруулж, оюутанд ээлтэй дотуур байрыг бий болгоно.
- 1.5.2. Хөдөлмөрийн хуульд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж, шинэ ажлын байр бий болгох бодлого баримтална.
- 1.5.3. “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ;
 - Төгсөгчдөд зориулан “Хийнгээ суръя - Орлого олъя - Хэмизэ” загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ;
 - Сурлагын өндөр амжилттай, бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулан, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэнэ;
 - Оюутны цагаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журмыг сайжруулж нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх, цагийн ажилд зуучлах системийг бий болгоно;
 - Бүтэн өнчин оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлж, орон нутгаас дэмжинэ
 - Залуучуудыг ажлын байраар хангаж, тасралтгүй суралцах, төрийн албаны залгамж халааг бэлтгэх зорилгоор “Ерөнхий болон тусгай шалгалт”-ын богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна.
 - Зах зээлийн эрэлттэй мэргэжлээр гадаад улсад мэргэжил эзэмшихэд бодлогоор дэмжинэ.
 - Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор ШАРК ТАНК хөрөнгө оруулалтын рeалити нэвтрүүлгийг олон нийтийн оролцоотойгоор хийж хэвшүүлнэ.
- 1.5.4. “Оюутан цэрэг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж дээд боловсрол эзэмших явцад иргэний журамт үүргээ биелүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амин дэмийн хэрэгцээг хангах, эрүүл чийрэг иргэн төлөвшүүлэх зорилгоор “СҮҮ” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Гэр бүл

- 1.5.6. "Тогтвортой гэр бүл" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- 1.5.7. Хувь хүн, гэр бүл, төрийн албан хаагч, хүүхэд залууст үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйн төвийг байгуулж, мэргэшсэн сэтгэл зүйчдийг ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.5.8. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ахмад настан

- 1.5.9. Ахмадын Цагаан-Уул амралт, Нэвт сувиллын газрыг 50-100 хүний багтаамжтай бие даасан байртай болгоно.
- 1.5.10. Ахмадын асаргаа, сувилал, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцсэн байдлаар зохион байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 1.5.11. "Ахмадаа ачилъя" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.5.12. Сум бүрд "Ардын өргөө" байгуулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

Малчид

- 1.5.13. "Залуу малчин, тариаланч" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Зудын эрсдэлийг даван туулах "ӨВӨЛЖӨӨ" төсөл хэрэгжүүлж хашаа хороо барих, өвөлжөөндөө амины сууц барихад дэмжлэг үзүүлнэ;
 - Малчин, тариаланчдын залгамж халааг бэлтгэнэ;
 - Малжуулах төсөл хэрэгжүүлнэ;
 - Ботгоны урамшууллыг жил бүр олгоно.
- 1.5.14. Алслагдсан бүс нутагт амьдарч байгаа малчдын хүүхдийг сургах ээлтэй нөхцөлийг бүрдүүлэх, залуу малчин гэр бүлийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд хүн амын нягтаршил бүхий багуудад бага сургууль, дотуур байр барина.
- 1.5.15. Малчин иргэдийн харилцаа холбооны тасалдалгүй байх хэрэгцээ, шаардлагын хүрээнд үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлж өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нутаг дэвсгэрийг гар утасны сүлжээнд бүрэн холбоно.

1.5.16. Бүх сумдын эмнэлгийг туулах чадвар сайтай орчин үеийн тээврийн хэрэгслээр ханган, Старлинкийн интернэтэд холбон малчид, хөдөө орон нутгийн иргэдэд алсын зайн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний үйлчилгээг үзүүлнэ.

1.5.17. Малчдын орлогын эх үүсвэртэй уялдуулж, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. НДШ-ийг сар бүр төлөхгүйгээр жилдээ багтаан төлөх, хувааж төлөх зохицуулалтыг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.5.18. Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

Эхчүүд, эмэгтэйчүүд

1.5.19. Жендерийн тэгш байдлыг хангах хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.

1.5.20. "Цалинтай эх, эцэг" нийгмийн хамгааллын бодлогыг нийгмийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан орон нутагт хэрэгжүүлнэ.

1.5.21. Эхчүүдэд зориулсан төрөлжсөн, мэргэжлийн асрах үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцүүлэн хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

Эрэгтэйчүүд

1.5.22. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд "Аав, эрчүүд", "Чанартай амьдрал - аавуудын оролцоо", "Эрүүл эр хүн" дэд хотөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.5.23. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

1.5.24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.5.25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлж дотоодын давуу эрх олгоно.

1.5.26. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг нэвтрүүлж, судалгаанд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

- 1.5.27. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын асрамжийн төвийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.5.28. Баруун бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийг түшиглэн иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.29. Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.5.30. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж иргэний эрхээ эдлэх боломжоор хангана.

1.6.Төрийн албан хаагч, ажилтны нийгмийн баталгаа

- 1.6.1. Сум болон аймгийн төвд ажиллаж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.6.2. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 1.6.3. Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлэн, төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлнэ.
- 1.6.4. Төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь "маш сайн" үнэлэгдсэн төрийн албан хаагчийг "1+2" буюу гадаадад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлого баримтална.
- 1.6.5. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 1.6.6. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтална.
- 1.6.7. Ажилтныг шударга үнэлэх, зохих цалин хөлсний хэмжээг тогтоох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг ажиллагсдад тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхэд Үйлдвэрчний эвлэлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлж нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрийг үр дүнд хүргэнэ.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд

1.6.8. “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулж, ejob.gov.mn платформоор дамжуулан ажилд зуучлах хөдөлмөрийн яармагийг улирал бүр тогтмол зохион байгуулна.

1.6.9. “Миний түрээсийн орон сууц” дэд хөтөлбөрт зорилтот бүлгийн өрхүүдийг хамруулна.

1.7. Хөдөлмөр эрхлэлт

1.7.1. Шинэ Ховд, Үйлдвэр технологийн парк, Агро парк, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, боомтын сэргэлт, уул уурхайн томоохон төслүүдийг түшиглэн бүсийн хэмжээнд 2500 ажлын байрыг шинээр бий болгоно.

1.7.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гүйцэтгэхдээ орон нутгийн иргэдийг түр болон байнгын ажлын байраар ханган ажилласан байдлыг харгалзан дотоодын давуу эрх олгоно.

1.7.3. Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.7.4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийж, үр дүнд үндэслэн хүний нөөцийг бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах, зуучлах ажлыг цогц байдлаар зохион байгуулна.

1.8. Соёл, урлаг

1.8.1. Үндэсний өв, уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн “ЖАНГАР” олон угсаатны өв соёл дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлан таниулж, урамшуулна;
- Олон угсаатны өв соёлын наадмуудыг зохион байгуулна;
- Хөөмий, тууль, домбор, уран нугаралт, бий биелгээний төрлүүдийг бодлогоор дэмжиж, өв тээгчдийг урамшуулна.

1.8.2. Үндэсний соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж, дэлхий дахинд сурталчлан таниулах замаар баруун Монголын өв соёлын орон зай, үнэ цэнийг өсгөх контент бэлтгэгчдийг дэмжинэ.

1.8.3. Угсаатны соёлын өвийг хадгалан хамгаалах, ондоошлыг илэрхийлсэн “Олон угсаатны урлаг дэлхийн тайзнаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.8.4. Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн музейн барилгыг барьж, соёлын үнэт олдвор, ховор үзмэрүүдийг орон нутагтаа хадгалан хамгаалж, иргэд, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.8.5. Олон улсын соёлын арга хэмжээнд Ховд аймгаа төлөөлөн оролцох уран бүтээлчдийг дэмжинэ.
- 1.8.6. Эртний түүхт Ховд хотын соёлын ордон байгуулна.
- 1.8.7. Төв номын сангийн барилгыг орчин үеийн стандартад нийцүүлэн шинээр барьж, танхим болон цахим уншлагын танхим байгуулж, номын фондыг нэмэгдүүлнэ.

1.9. Спорт

- 1.9.1. Нийтийн спорт хөгжих орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд стандарт шаардлага хангасан хөл бөмбөгийн талбай байгуулна.
- 1.9.2. 3х3 сагсан бөмбөгийн талбайг сум бүрд байгуулна.
- 1.9.3. Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлнэ.
- 1.9.4. Ховд аймгийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлж, "АВАРГА" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Олимп, дэлхий, олон улс, улсын хэмжээний спортын тэмцээн, уралдаанд амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагчдыг урамшуулна;
 - Үндэсний спортын төрлүүдээр амжилт гаргасан тамирчдыг урамшуулна;
 - Олон улсын болон улс, бүсийн аварга шалгаруулах спортын тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна;
 - Бисийн тамир, спортын салбарыг шаардлагатай тоног төхөөрөмж, спорт хэрэгслээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна;
 - Сум бүрд спортын дасгалжуулагч ажиллуулна;
 - Үндэсний спортын холбоод болон бусад холбоодод жил бүр дэмжлэг үзүүлнэ.
- 1.9.5. Баруун бүсэд 3000-5000 хүний суудалтай "KHOVD PALACE" спорт цогцолборыг шинэ суурьшлын бүсэд шинээр барина.
- 1.9.6. "Алдрын түүхээ" үндэсний бөхийн чуулга барилдааныг жил бүр уламжлал болгон Ховд бөхийн дэвжээтэй хамтран зохион байгуулна.

- 1.9.7. Спортын холбоодтой хамтран ажиллаж нийтийн биеийн тамир болон мэргэжлийн спортуудыг тэгш хөгжүүлнэ.
- 1.9.8. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын (урбан) спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийг суурин газруудад бүтээн байгуулна.
- 1.9.9. Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудыг түшиглэн шинээр спорт заал барьж, хүүхэд залууст чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэж, эрүүл чийрэг бие бялдартай болоход бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.9.10. Жаргалант сумын бага зааланд их засвар хийж иргэд үйлчлүүлэх ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ.



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

2.1 Улсын болон орон нутгийн төсвийн бодлого

- 2.1.1. Эдийн засгийн үр өгөөжтэй, ажлын байр бий болгох төсөл, хөтөлбөр, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, дэмжлэгээр санхүүжүүлэх бодлого баримтална.
- 2.1.2. Бизнесийн бүх салбаруудыг дэмжиж эдийн засгийн хувьд бие даасан аймаг болно.

2.2 Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт уул уурхайн шилжилт

- 2.2.1. Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох ажлыг иргэдийн санал хүсэлтэд үндэслэн шийдвэрлүүлнэ.
- 2.2.2. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, Хөшөөтийн уурхайн тоосжилтын хүн болон мал амьтан, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах дэвшилтэт технологид тулгуурласан нүүрс угаах үйлдвэрийг барина.
- 2.2.3. Уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх замаар хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж дүйцүүлэн хамгаална.
- 2.2.4. Хөшөөтийн нүүрсний уурхайд ажиллаж буй тээвэрчид, уурхайчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хөдөлмөр хамгааллыг хангахад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулна.
- 2.2.5. Ховд аймагт Хөшөөтийн уурхайгаас ирэх үр ашгийг нэмэгдүүлж орон нутгийн компаниудыг дэмжих, хамтран ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3 Нэмүү өртөг шингээсэн боловсруулах үйлдвэр

- 2.3.1. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг шинээр барьж ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулж ажлын байр бий болгож, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.3.2. Барилгын арматурын үйлдвэрийг барьж баруун бүсийн иргэдийг хямд үнэтэй орон сууц худалдан авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.3. Хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшил тогтоож, дахин боловсруулахад Япон улсын туршлагыг нэвтрүүлж, дэвшилтэт технологиор дахивар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр байгуулна.

2.3.4. Бага оврын нефть боловсруулах үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

2.4. Боомтын сэргэлт, бүс холбосон зам, тээвэр, логистик

2.4.1. Мянганы замын Ховдын Мянгад-Завханы Загастайн давааны арын уулзвар чиглэлийн 426 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.2. Мянганы замын Ховдын Мянгад-Хонгиогийн гүүр хүртэлх 32 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.3. Ховд – Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замыг барина.

2.4.4. Босоо, хэвтээ тэнхлэгийн замын огтлолцлыг түшиглэн хуурай боомтыг байгуулна.

2.4.5. Ховд Нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөл хийнэ.

2.4.6. Евро-Азийг холбосон хамгийн дөт зам Шивээхүрэн боомт - Арцсуурь боомт чиглэлийн баруун босоо тэнхлэгийн 725 км төмөр замыг барина.

2.4.7. Булган, Байтаг боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, ачаа тээврийн бүртгэл, гаалийн хяналт шалгалтыг автоматжуулж, рентген, камер, автомат хаалга, автомат жин, шинжилгээний төхөөрөмжийг суурилуулан боомтын “Ухаалаг гарц”-ыг бүрэн ашиглалтад оруулна.

2.4.8. Мөнххайрхан, Дуут сумыг аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбож бүх сумаа хатуу хучилттай авто замаар холбосон анхны аймаг болно.

2.4.9. Улс, хот хоорондын ачаа, авто тээврийн мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгон олон улсын жишигт хүргэж иргэд үйлчлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.10. Нийтийн тээврийн үйлчилгээг дэмжин, ухаалаг үйлчилгээг нэвтрүүлж, иргэдэд үйлчлэх тав тухтай байдлыг нэмэгдүүлнэ.

2.4.11. Булган суманд малын эрүүл ахуйн хорио цээрийн бүс байгуулж, мал, махны экспортыг нэмэгдүүлнэ.

2.5. Эрчим хүчний шилжилт

2.5.1. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж, баруун бүс нутгийг хямд өртөгтэй эрчим хүчээр хангана.

2.5.2. Эрдэнэбүрэн – Мянгад - Улиастайн чиглэлийн 220 кВ-ын 468.3 км цахилгаан дамжуулах агаарын шугам татна.

- 2.5.3. Алтай, Булган, Үснч сум, зарим сумдын багийн төвийг цахилгаан дамжуулах нэгдсэн шугам сүлжээнд холбоно.
- 2.5.4. Буянт, Мөст сумыг дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбож бүх сумдаа дулааны эх үүсвэрээр хангана.
- 2.5.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг бодлогоор дэмжинэ.
- 2.5.6. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 2.6. **Дөрвөн улирлын аялал жуулчлал ба Соёлын бүтээлч үйлдвэрлэл**
- 2.6.1. “Мөнгөлөг шагшuurга” цас мөсний баяр, “Жангар-Цайны зам” өв соёлын наадмыг үргэлжлүүлж, гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 2.6.2. Гурван Сэнхэр, Дөргөн нуур, Хар ус нуур, Буянт, Ховд гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд, Хил орчмын бүсийг түшиглэсэн аялал жуулчлалын бааз байгуулах санал санаачлагыг дэмжинэ.
- 2.6.3. Ховд аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялагчдын аялах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аялал жуулчлалын түр буудаллах цэгийг Булган, Манхан, Мөст, Дарви, Эрдэнэбүрэн сумдад байгуулна.
- 2.6.4. Аялал жуулчлалын бүс нутгууд болох Эрдэнэбүрэн сумын Намарзан баг, Мөст сумын Баянзүрх, Бодончийн хавцал, Алтай сумын Ямаан усны хавцал, Чандмань сумын Дөргөн хатан нуур, Жаргалант сумын Буянт гол, Дарви сумын Сутай, Булган сумын Бүдүүн харгайтын голыг түшиглэн жуулчдын отоглох цэгийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 2.6.5. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээлээр дэмжих бодлого баримтална.
- 2.6.6. Аялалын гол маршрутуудын дагуу жуулчдад зориулсан тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбарыг байршуулж, дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.6.7. Өөрийн орны өвөрмөц онцлог, нөөц, олон улсын чиг хандлага, технологийн хөгжилтэй уялдсан, мэдлэгт суурилсан бүтээлийг дэмжиж, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх бүтээлч экосистемийг дэмжих “Соёлын бүтээлч үйлдвэрлэл III” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.6.8. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг (AR, VR, MR, 3D) ашиглаж, “Цахим соёл II”, “Соёлын эрхийн бичиг” системийг орон нутагтаа нэвтрүүлнэ.

2.6.9. Алтайн нуруу, их нууруудын экосистемд түшиглэсэн адал явдалт, ангийн, угсаатан зүй, хил орчмын болон хил дамнасан, олон угсаатны аялал жуулчлалыг кластер бүсчлэлээр хөгжүүлж, Их нууруудад түшиглэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

2.6.10. Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулна.

2.7. “Шинэ хоршоо” хөдөлгөөн- Хөдөөгийн сэргэлт

2.7.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг орон нутгийн хэмжээнд өрнүүлж, хоршоологчдыг дэмжинэ.

2.7.2. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг бүрдүүлнэ.

2.7.3. Агро парк, Шинэ хөдөө төслийн хүрээнд худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.7.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дутагдалтай байгаа малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэхэд орон нутаг бодлогоор дэмжинэ.

2.7.5. Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

2.7.6. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байр бий болгох бодлогыг сум бүрд хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

2.7.7. Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлнэ.

2.7.8. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон салбар болгон хөгжүүлнэ.

2.7.9. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.7.10. Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлана.

2.7.11. Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг байгуулна.

- 2.7.12. Малын тэжээлийн баруун бүсийн үйлдвэрийг байгуулж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 2.7.13. Гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх хувийн хэвшлийн санаачилгыг бодлогоор дэмжинэ.
- 2.7.14. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорины аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, аймгийн хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 2.7.15. Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 2.7.16. Газар тариалан эрхлэгчдийг дэвшилтэт технологид суурилсан техник, тоног төхөөрөмжөөр хангахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт, экспорт

- 2.7.17. "Шинэ Ховд" хөнгөн үйлдвэрлэл технологийн паркийг түшиглэн мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хагас болон гүн боловсруулах инновац, технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.7.18. Сүү, цагаан идээ, мах, ноолуур, арьс ширийг нэмүү өртөг шингээн дотоод, гадаадын зах зээлд өндөр үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.
- 2.7.19. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.7.20. Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалтаатай тариалангын талбайн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж, "Атар IV" аяныг хэрэгжүүлнэ.
- 2.7.21. Ховд аймгийн онцлогт түшиглэн газар тариалангийн салбарт олон улсын дэвшилтэт технологи нэвтрүүлж, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлж тариаланчдын орлогыг 2-3 дахин өсгөнө.
- 2.7.22. Зооноз өвчин судлалын төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

Эрүүл хүнс

- 2.7.23. Тарвас, Булганы алимыг газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр баталгаажуулж экспортын брэнд бүтээгдэхүүн болгоно.
- 2.7.24. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.
- 2.7.25. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, стандартыг нэмэгдүүлж, эрүүл, чанартай хүнс хэрэглэх тогтолцоог сайжруулна.
- 2.7.26. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар орон нутгийн малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.
- 2.7.27. Баруун бүсийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулж иргэдийн хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.

ГУРАВ. ХӨГЖЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

3.1. Төр нь хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй

- 3.1.1. Булган, Байтаг боомтоор хувь хүн, ААН-үүдийн импорт, экспортын бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдэд ээлтэй, шуурхай үйлчилгээний шинэ менежментийг бий болгоно.
- 3.1.2. Орон нутгаас зарлагдаж буй төрийн худалдан авах ажиллагаанд орон нутгийн аж ахуйн нэгж, компаниудыг бодлогоор дэмжиж, чадавхжуулна.
- 3.1.3. Бизнес эрхлэлтийг бодлогоор дэмжиж төрөөс зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод, түргэн шуурхай болгоно.
- 3.1.4. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин ажиллаж, хамтарсан хяналтын тогтолцоог бий болгоно.

3.2. Шинэ ажлын байр

- 3.2.1. Томоохон бүтээн байгуулалт, уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компаниудыг орон нутгийн аж ахуй нэгж, жижиг дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг бойжуулах зорилгоор дэмжих, туслан гүйцэтгэгчээр ажиллуулах, худалдан авалт хийх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.3. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг орон нутгийн худалдан авалтаар дэмжинэ.
- 3.2.4. Ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 3.2.5. Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, хөрөнгө оруулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ТӨРИЙН БҮТЭЭМЖ БА ЦАХИМ ЗАСАГЛАЛ

4.1. Цахим засаглал

- 4.1.1. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар иргэдийн хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "ухаалаг E-Mongolia" системийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах замаар төрийн үйлчилгээг иргэдэд ээлтэй, хурдан шуурхай болгох ажлыг чанарын шинэ шатанд гаргана.
- 4.1.2. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүний оролцоогүй болгох дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.1.3. Төрийн үйлчилгээний 24 цагийн цахим төвийг бүх сумдад байгуулна.
- 4.1.4. Олон улсын цахим төлбөрийн системүүдийг нэвтрүүлж, төлбөр тооцоог саадгүй хүлээн авах боломжийг орон нутагтаа бүрдүүлэн цахим худалдааг дэмжинэ.
- 4.1.5. Мэдээлэл технологийн салбарын инженерүүдийг бэлтгэх, чадавхжуулах бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.1.6. Баруун бүсийн дата төвийг Ховд аймагт байгуулна.
- 4.1.7. Хур-Дан төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 4.1.8. Invest Khovd, My Khovd, Visit Khovd төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн үйл ажиллагааг өргөтгөнө.
- 4.1.9. Интернэтийн 5G сүлжээг бүрэн нэвтрүүлнэ.

ТАВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН

5.1. Уур амьсгалын өөрчлөлт

- 5.1.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй ажил, үйлчилгээ, бизнесийг орон нутгийн бодлогоор дэмжинэ.
- 5.1.2. Хүлэмжийн хийг бууруулах стратегийг утаа, эрчим хүч, өрхийн халаалтын шийдэл, цөлжилт зэрэг тулгамдсан асуудлууд руу чиглүүлж, олон улсын байгууллагуудаас санхүүжилт татах бодлого хэрэгжүүлнэ.
- 5.1.3. Аймгийн ус цаг уурын орчны шинжилгээний салбарт өндөр технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн техникийн шинэчлэл хийж, цаг уур, гамшгийг эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана.
- 5.1.4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх дэвшилтэт технологи ашиглах хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.5. Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлыг хамгаалах, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлийн олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.1.6. Хар ус нуурын эко системийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

5.2. Уламжлалт нүүдлийн аж ахуй

- 5.2.1. Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг дэмжих замаар бэлчээрийн доройтлыг бууруулна.
- 5.2.2. Залуу малчдыг уламжлалт болон эрчимжсэн мал маллах арга ухаанд сургах, залгамж халааг бэлтгэнэ.
- 5.2.3. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах замаар ашиглагч-малчдыг хариуцлагажуулна.
- 5.2.4. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 5.2.5. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 5.2.6. Эвдэрсэн худаг, уст цэгийг сэргээж, бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлнэ.

5.3. Үнэт баялаг ус

- 5.3.1. Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.
- 5.3.2. Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, саарал ус ашигладаг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 5.3.3. Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, үйлдвэрлэлийн ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.3.4. Суурин газруудын ундны усан хангамжийн эх үүсвэрийг бий болгож, ухаалаг систем нэвтрүүлж тоолууржуулна.
- 5.3.5. Усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлнэ.

5.4. Ногоон эдийн засгийн шилжилт

